



Дугаарын **60** мөр
Элс, цасаа
мөнгө болгоё

АН-ын даргад нэр дэвшигчид ҮНЭМЛЭХЭЭ ГАРДАЖ АВЛАА

Б.ДАВАА

Дэлхийн өнцөг булан бүрээс жуулчид БНХАУ руу цувах болжээ. Тэдний гол зорилго нь ердөө нэг хүүг харах. Хятадын хамгийн баян хүн "Алибаба" группыг үүсгэн байгуулагч Жак Матай усны дусал мэт адилхан нэгэн хүүг харахын тулд л жуулчид "ноён ногоон"-оо барин хэдэн бээрийг туулан өмнөд хөршид зорчих болсон аж. Фан Шианши гэх хүү Хятадын өмнөд этгээдийн Жианши мужийн ядуу тосгонд амьдардаг бөгөөд түүний зураг социал сүлжээнд цацагдаж эхэлсний дараа өдөртөө 50 жуулчин ердөө л тэр хүүг харж, бэлэг өгөх зорилгоор Хятадыг хөндлөн гулд туулах болж. Тэд сонинч зандаа хөтлөгдөж ийнхүү аялж байна.

Үргэлжлэл нь III нүүрт



Ж.ОТГОН

Ардчилсан намын даргад нэр дэвшигчдийн үнэмлэхийг гардуулах ёслолын ажиллагаа өчигдөр боллоо. АН-ын даргад өрсөлдөхөөр зохих журмын дагуу хүсэлтээ хүргүүлээд буй С.Эрдэнэ, Д.Эрдэнэбат, Л.Гантөмөр, Ж.Батзандан, Н.Алтанхуяг нарын таван хүн үнэмлэхээ гардан авсан юм. Үнэмлэх гардуулах ёслолын ажиллагааг нээж АН-ын дарга З.Энхболд "АН-ын даргын сунгаа манай намын түүхэнд сайн, муугаар бичигдсэн байдаг. Үүнийг манай таван нэр дэвшигчид сайнаар авч явах байх. Намын даргын сунгаа дүрмийн дагуу явж байгаа. Энэ дүрэмд хэн нэгнийг намд байсан хугацаагаар нь ялгаагүй. Бид хөгшин байна чамайг оруулахгүй гэж хэлээгүй. Сунгаанд оролцуулсангүй гэж социалд гомдоллохоо боль. Намын даргад нэр дэвших бүх гишүүдэд нээлттэй байсан."

Үргэлжлэл нь VI нүүрт

FLEX GYM "FLEX GYM" фитнес төвөөс санаачилсан
"ЭМХ" ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

Эрүүл монгол хүн
Төсөлд хамрагдсанаар:

1 жил хичээллэх = 1 сая ₮

Нэг хүнээс шууд урамшуулал 80.000 ₮

Дараах бэлгийн эзэн болно

Маркетингийн алба: 88111719, 99903191, 99902646

УЗЭЛ БОДОЛ

Хүчирхийлэл үйлдэх хүмүүжүүлэх хоёрт ЯЛГАА БИЙ ШҮҮ

Н.ЛУНЦАГБОЛД

Нийгэмд хамгийн их хүлээлт үүсгэж, басхүү анхаарлын төвд орчихоод байгаа нь асуудал бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж гаргах. Мэдээж энэ хуулийн төслийг шат шатандаа хэлэлцээд, хэдэн гишүүд чуулган дээр үг хэлж, үзэл бодлоо уралдуулж байгаад л батална, энэ тодорхой. Баглах ч ёстой юм. Өнөөдөр нийгэм даяараа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа хүмүүсийг яснаасаа үзэн ядаад эхэлчихсэн. Эхнэрээ гэгээн цагаан өдөр хөнөөсөн, бяцхан охиноо зэрлэг балмадаар зодож амь насыг нь сүйтгэсэн хэргийг монголчууд мартаагүй байна. Хамгийн сүүлд гэхэд жирэмсэн эхнэрээ зодоод алчихсан зэрлэг хирдхийлгэм хэрэг гарсан. Монголчууд улам л бухимдаж, хурдан хатуухан шиг хууль баглаад, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа ухаанд нь ухна ишиг үхчихсэн хүмүүсийг шийтгээд өгөөч гээд л байна. Зөвөө, зөв. Өнөөдөр

нөхөртөө долоо хоногтоо хэд зодуулчихаад, хүүхдээ бодоод тэвчиж, нулимсаа барж яваа бүсгүйчүүд хэд байгаа бол. Аавдаа зодуулаад, бүрдэглүүлж, уйлж хоноо хүүхэд хэчнээн байгааг бид мэдэхгүй. Энд жижигхэн тоо баримт дурьдая. 2010 онд гэхэд гэр бүлийн хүчирхийллийн улмаас есөн хүн нас барж байж. Тэгвэл 2016 оны эхний 10 сарын байдлаар 1066 гэмт хэрэг гарч, 10 хүн нас барж, 1000 хүн гэмтсэн байгаа юм. Гэр бүлийн хүчирхийлэл өнгөрсөн оны мөн үеийн даруй 38.8 хувиар өссөн байна.

Үргэлжлэл нь III нүүрт

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Ж.ОТГОН

"Yes! Mongolia" Монголын залуу багш нарын холбоо 21 аймаг, нийслэлийн боловсрол соёлын газруудтай хамтран "Оюуны элч-2016" оны шилдэг залуу багшийг шалгаруулахаар болжээ. Энэ талаар тус холбооны ерөнхийлөгч Н.Учралтай ярилцлаа.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.Учрал: НИЙГЭМД ОЮУН САНААНЫ ӨӨРЧЛӨЛТ АВЧРАХ "ОЮУНЫ ЭЛЧ"-ҮҮДИЙГ ШАЛГАРУУЛНА

-Таны тэргүүлдэг Монголын залуу багш нарын холбоо хэзээнээс үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм бэ. Нэлээд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бололтой?

-Монголын залуу багш нарын холбоо маань анх 2010 онд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Энэхүү холбоог анх нийслэлийн Баянзүрх дүүргийн залуу багш нар нэгдэж байгуулж байлаа. Харин өнөөдөр тус холбоо маань нийслэлийн есөн дүүрэг, 21 аймагт салбар зөвлөлтэй үндэсний хэмжээний томоохон байгууллага болон өргөжин хөгжөөд байна. Миний хувьд

2015 онд уг холбооны тэргүүнээр сонгогдон ажиллаж эхэлсэн. Холбоог тэргүүлэх болсон цагаас эхлэн холбооныхоо үйл ажиллагааг илүү тодорхой болгох, олон улсын төвшинд аваачихыг зорин ажилласан.

Үргэлжлэл нь IV нүүрт

ХААН банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2484.00	2494.00	ФУНТ	3049.00	3153.00	АМ.ДОЛЛАР	2480.00	2494.00
ЕВРО	2564.00	2634.00	РУБЛЬ	38.50	41.90	ЕВРО	2566.00	2648.00
ИЕН	20.90	21.25	ЮАНЬ	356.00	359.40	ИЕН	20.85	21.51
						ФУНТ	3066.00	3160.00
						РУБЛЬ	39.06	42.38
						ЮАНЬ	356.50	361.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Шинэ нисэх буудлын нислэгийн журмын ажил дуусах шатандаа оржээ

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын хэрэглэлийн нислэгийн журмын тэдгээрийн төсөл зургуудыг Нислэгийн журам боловсруулалтын алба (НЖБА)-наас өчигдөр танилцууллаа. НЖБА нь нислэгийн журмын зохиолтыг энэ оны зургаадугаар сараас "ИСА" байгууллагын зөвлөхийн дэмжлэгтэй эхэлж одоогийн байдлаар тус журмуудыг нислэгээр баталгаажуулахад бэлэн болсон байна. Өнгөрсөн хугацаанд НЖБА нь Зам, тээвэр хөгжлийн яамны Нислэг, техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба, ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын алба, Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, МИАТ ТӨХК зэрэг байгууллагуудын төлөөлүүдийг оролцуулан Нислэгийн журмын ерөнхий төлөвлөлт (Conceptual design) болон Нарийвчилсан зохиолтын (Detailed design) багуудыг бүрдүүлэн нийт 12 удаагийн уулзалт, зөвлөгөөн, хурал зургийг амжилттай зохион байгуулж, голлох асуудлуудыг шийдвэрлэжээ. Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудалд Уламжлалт болон Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN) ашигласан APCN, SID, STAR, Missed Approach, Holding, Circling зэрэг нийт 65 нислэгийн журам зохиосон бөгөөд тус журмуудыг нислэгээр шалган баталгаажуулсны дараа 24 схем зураг болгон Нисэхийн

ОРОН НУТГИЙ ХӨГЖЛИЙН САНГААР ДАМЖУУЛЖ ТӨСВИЙН ТӨВЛӨРЛИЙГ БУУРУУЛЪЯ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.ПУНЦАГБОЛД

Улаанбаатар хотод хэт төвлөрөл үүсч, тэр хэрээрээ араасаа аюул дагуулж байгаа билээ. Агаар, хөрсний бохирдол дээд цэгтээ хүрч, автомашины түгжрэл асуудал болсоор байна. Тэгвэл өчигдөр “Монгол Улс дахь төвлөрлийг сааруулах бодлого ба иргэний оролцоо” сэдэвт Олон улсын бага хурал Төрийн ордонд Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд боллоо. Энэхүү хуралд Монгол Улс, Индонез, Киргизстан, Узбекистан, Непал, Лаос, Камбож, Мьянмар зэрэг орны төлөөлөгчид оролцсон юм. Мөн энэхүү бага хуралд зарим аймаг, сум, дүүргийн төлөөлөл оролцон илтгэл хэлэлцүүлж, орон нутгийн хэмжээнд хийж хэрэгжүүлсэн ажил, туршлагаасаа хуваалцсан билээ. Хурлыг Ерөнхийлөгчийн Иргэний оролцоо, эдийн засгийн бодлогын зөвлөх Л.Дашдорж хөтлөн явуулсан. Ерөөс энэхүү бага хурлын гол чиглэл нь Орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулж яаж төвлөрлийг бууруулж болохыг жишээгээр харуулж, тайлбарлаж, таниулсан явдал байлаа. Цаашлаад Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг жилээс жилд бууруулж байгааг зогсооход энэ хурлын гол зорилго чиглэж байсан юм. Олон улсын бага хурлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан нээж үг хэлсэн. Тэрбээр “Хүний эрх, эрх чөлөөлөг дээдэлсэн Хүмүүнлэг ардчилсан нийгэмд шилжсэнээс хойшхи 25 жилийн хугацаанд бидэнд олсон амжилт олон хэдий ч төсвийн төвлөрлийг сааруулж орон нутагт эдийн засгийн эрх мэдэл олгох, төсвийн

зарцуулалтыг ил тод мэдээлж түүнд иргэд олон нийт хяналт тавих эрхийг олгох, улмаар төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах асуудал хойшлуулшгүй байгааг Монгол Улсын Ерөнхийлөгч онцгойлон анхаарч холбогдох хуулийг санаачлан УИХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. Төвлөрлийг сааруулах бодлого нь Үндсэн хуульд заасан нийгмийг бэхжүүлэх нэгэн суурь болно гэж үзэж байна. Улсын Их Хурлын “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” 2016 оны 19 дүгээр тогтоолд “Төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах нь тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим болохыг тодорхойлсон. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын тэргүүлэх чиглэлийг үндэслэсэн хариуцлагатай, ил тод, сайн засаглалыг дэмжин хөгжүүлэх үзэл санаанд тулгуурлан Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор батлаад байна. 2013 онд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад төсвийн төвлөрлийг сааруулахад нэгэн чухал үзэл баримтлалын шинэчлэлт оруулсан нь орон нутагт эрх мэдлийг бодитой олгох, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалт оруулсан явдал юм” хэмээн хэлсэн. Тэгвэл нээлтийн дараа Сангийн яамны зарлагын хэлтсийн дарга О.Хуягцогт “Төсвийн төвлөрлийг сааруулах бодлого ба орон нутгийн хөгжлийн сан” сэдвээр илтгэл тавьсан юм. Улс оронд дөрвөн

төрлийн төвлөрөл байдаг аж. Улс төрийн, захиргааны, санхүү төсвийн, эдийн засгийн гэсэн дөрвөн төвлөрөл. Манай улсад бол энэ бүх төвлөрөл байгаа. Манай улсын хувьд төсвийн төвлөрлийг бууруулах замаар Улаанбаатар хотын төвлөрлийг багасгах арга хэрэглэж эхэлсэн нь Орон нутгийн хөгжлийн сан байсан аж. Монгол Улсын төсвийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2013 оны нэгдүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн. Тэр үеэс орон нутгийн хувьд хамгийн ач холбогдолтой Орон нутгийн хөгжлийн санг байгуулсан. Ингэснээр орон нутагт төсвийн эрх мэдэл орон нутагт бага ч болов шилжсэн. Тухайлбал, 2009 онд нэгдсэн төсвийн орлогод эзлэх орон нутгийн төсвийн орлого 14.2 хувь байсан бол 2015 онд 34 хүртлээ нэмэгдсэн байгаа юм. Ингээд л сум орон нутгийн удирдлагууд өөрсдөө Орон нутгийн хөгжлийн сангаараа дамжуулж, нутгаа хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг дээшлүүлж эхэлсэн. Харин одоогийн хуулиар ОНХС-гийн хөрөнгийн 40 хувь нь нийслэл, аймагт, 60 нь сум. Дүүрэгт очдог байсан. Тэгвэл 2017 оны төсвийн тухай хуульд орон өөрчлөлтөөр 70 хувь нь нийслэл, аймагт, 30 нь сум, дүүрэгт очихоор болоод байгаа аж. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн мөнгө жил ирэх тусам буурч байгаа юм байна. Тухайлбал, 2013 онд аймгуудад 209.6 тэрбум төгрөг хуваарилсан бол 2014 онд 284.5 болж, дээд цэгтээ хүрээд бууж эхэлж. 2015 онд огцом буурч 126.8, 2016 онд 120, 2017 онд 74.5 болж буурсаар байгаа аж. Энэ нь цаашид төсвийн төвлөрлийг

бууруулах үйл явж зогсч магадгүйн илэрхийлэл юм байна. Тиймээс ОНХС-гийн хөрөнгийг хүрсэн төвшнөөс бууруулахгүй байх шаардлагатайг тэрбээр илтгэлийнхээ үеэр онцолж байлаа. Түүний дараа Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Батсуурь аймгатаа ОНХС-гийн хөрөнгөөр яаж бүтээн байгуулалт өрнүүлж, төвлөрлийг бууруулахад хувь нэмрээ оруулж чадсан талаараа илтгэл тавьсан юм. Мөн ОНХС-гийн хэрэгжилтийг хэрхэн Сүхбаатар аймагт үр дүнтэй хэрэгжүүлсэн туршлагаасаа хуваалцлаа. Тэрбээр илтгэлийн эхэнд зарим нэг санааг хэлж, захисан. Тухайлбал, ОНХС-д хуваарилж өгч байгаа төсөв буурснаар орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хумигдаж, гурав дахин буурсан гэдгийг ч хэлсэн юм. Мөн тэрбээр “Манай аймгийнхан 4-8 жилийн төлөвлөгөө гаргаж, нэр тэргүүнд хийх шаардлагатай ажлынхаа жагсаалтыг гаргасан. Тэгээд түүн дээрээ тулгуурлаж иргэдээс санал авсан. Ер нь тэгэх нь зөв юм билээ. Тэгэхгүй иргэдээс санал авна гэхээр МСҮТ-нийхөн зохион байгуулалттайгаар ирээд өөрсдийнхөө асуудлыг шийдүүлэх гэдэг. Эсвэл ахмадууд цуглаад нэг асуудал яриад байдаг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бид гол тулгуураа болгож, олон ажлыг хийж чадсан. Тухайлбал, 967 иргэнийг нүүлгэж, 830 шахам объектынг шилжүүлж, нийтдээ 115.5 га газар чөлөөлсөн. Улмаар дахин төлөвлөж, эмх цэгцэнд оруулж чадсан. Ингэснээр иргэдээс гарах урсгал зардал дөрөв дахин буурч байх жишээтэй. Аймгийн Засаг даргын тамгын газрын өмнөх

газрыг чөлөөлж, дэлхийн жишигт нийцсэн хөлбөмбөг, хоккейн талбай байгуулсан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дэд бүтцийг нь шийдээд, жишиг хороолол, бага, дунд орлоготой иргэдийн орон сууц, бичил хаус хороолол, төвлөрсөн орон сууц барилдаа. Сүхбаатар аймагт 2003 онд ердөө л 38 иргэн орон сууцанд орж байсан бол 2013 онд 210, 2014 онд 328, 2015 онд 185 иргэн орон сууцанд орсон. Мөн бид хуучирсан байшингууд байсныг засварлаж, 636-хан сая төгрөг зарцуулаад, ахмадын сувилал байгуулсан. Өдөрт 50 хүн хүлээж авах чадалтай. Хэрвээ ийм сувилал шинээр барьвал 2, 3 тэрбум төгрөг зарцуулах байсан. Мөн бид ОНХС-гийн хөрөнгөөр хэд хэдэн уулзварын зураг төслөө гаргаж, тэр дагуу хөрөнгө оруулалт татаад замаа барьж чадсан. Сүхбаатар аймаг төвдөө ердөө таван км замтай байсан бол одоо 50 км болсон. Дээрээс нь сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, гэрэлтүүлэг гээд бүхий л асуудлыг цогцоор нь шийдэж байгаа. Мөн ОНХС-гийн хөрөнгөөр сумдаа хөгжүүлж чадсан. Нэг жил бүх сум тохиожилт хийх, нөгөө жил когноосоо салах, дараа нь гэрэлтүүлэг шийдэх зэргээр асуудлыг шийдсэн. Бүх сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө гаргасан байгаа. Энэ мэтээр ОНХС-гийн хөрөнгө байсны ачаар хийж хэрэгжүүлсэн ажил их байна. Үүний үр дүнд аймгийн хүн ам сүүлийн найман жилийн хугацаанд 7000-аар нэмэгдсэн. Мал сургийн тоо 3.1 сая болж өссөн. ОНХС хэрэгжээгээр жижиг, дунд үйлдвэрлэл, хоршооллын үйлчилгээ эрхлэгчдийн тоо 613-т хүрч, шинээр 1497 ажлын байр бий болж, 994 ажлын байр хадгалагдсан. Ажилгүйдлийн төвшин 7.8 хувь болж буурлаа. Аймаг үндсэн үзүүлэлтээр Орхон, Өмнөговь, Дархан-Уул аймгийн дараа дөрөвдүгээрт орж байна. Эдийн засгийн тамир тэнхээгээр тавдугаарт жагсч байгаа” хэмээн ярьсан юм. Түүний араас Ховд аймгийн ИХТ Д.Баасандорж ч мөн ОНХС-гийн хөрөнгөөр аймаг, орон нутгаа яаж өөд нь татсан, Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ч багасч байгаа талаар илтгэл тавьсан юм. Ерөнхий мэдээлэл өгөхөд хэдхэн жилийн өмнө Улаанбаатарт жилдээ 6000 хүн шилжиж ирдэг байсан. Харин ОНХС бий болж, орон нутаг хөгжиж, ажлын байр нэмэгдэж эхэлснээр жилдээ 2000 хүн Улаанбаатараас шилжиж байгаа гэсэн тоо гарсан байгаа юм. Энэ мэтээр төсвийн төвлөрлийг сааруулах ажил үр дүнгээ өгч эхэлсэн байна.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.АНТГОГО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчлаланы алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

Казахстан улсын Элчин сайдыг хүлээн авч үүлзлээ

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Бүгд Найрамдах Казахстан Улсаас манай улсад суугаа Элчин сайд Калыбек Кобландиныг хүлээн авч үүлзлээ. Хоёр орны харилцаа 25 жилийн ойн босгон дээр ирж буйг тэмдэглээд энэ хугацаанд манай хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж ирсэнд сэтгэл хангалуун байгаагаа Ерөнхий сайд уулзалтын эхэнд хэллээ. Мөн Казахстан Улс тусгаар тогтнолоо зарласны 25 жилийн ойн баярын мэнд хүргэлээ. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол Казахстаны Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн даргаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр томилсон.

Ээлжит хуралдааны товч тохирч, хоёр талд тааламжтай үед амжилттай зохион байгуулна гэдэгт найдаж байна гэлээ. Улаанбаатар хотноо өнгөрөгч аравдугаар сард бизнес форум болсон. Бизнесийн ийм арга хэмжээ хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулахад түлхэц болно гэж үзэж буйгаа Элчин сайд тэмдэглээд ирэх оны зургадугаар сард Астана хотноо болох “ЭКСПО 2017”-д 105 орон оролцохоо илэрхийлсэн. Монгол Улс энэ арга хэмжээнд оролцож өв, соёлоо сурталчилна гэдэгт итгэлтэй байгаа гэлээ. Уулзалтын үеэр хоёр орны худалдаа эдийн засаг, иргэд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг асуудлаар ярилцлаа гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэсээ мэдээллээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН

УИХ дахь МАН-ын бүлгийн ээлжит хурлаар Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Ард нийтийн санал асуулгын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх асуудлыг

Д.ХАЯНХЯРВАА: Гишүүд байнгын хорооны болон нэгдсэн чуулганд цагтаа ирнэ

хэлэлцжээ. Бүлгийн хурлаас дээрх хуулиудад өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судалж үзэх ажлын хэсгүүдийг байгуулсан тухай МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа мэдээллээ. Үндсэн хууль болон Ард нийтийн санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Д.Лүндэжванцан, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах эсэхийг судлах ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Ц.Цогзолмаа, Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Н.Цэрэнбат нарыг томилсон бөгөөд дүгнэлтээ энэ онд багтаан МАН-ын бүлэгт танилцуулахаар болжээ.

Мөн Туул голыг тусгай хамгаалалтад авах болон цэвэрлэх байгууламжуудтай холбоотой асуудлаар УИХ-ын зүгээс хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн тухай МАН-ын бүлгийн гишүүд санал бодлоо солилцсон байна. МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа “Өнгөрсөн долоо хоногт бүлгийн гишүүдийн ирцгээй холбоотой асуудал яригдлаа. Цаашид УИХ-ын гишүүдийн хариуцлага ямар байх, байнгын хороо болон УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанд хэрхэн цаг баримталж оролцох асуудлаар гишүүд нэгдсэн байр суурианд хүрсэн. Гишүүд байнгын хорооны болон нэгдсэн чуулганд цагтаа ирнэ. Гадаад, дотоод томилолт, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд олон түмэнд нээлттэй мэдээлж байхаар болсон” гэв. Мөн тэрбээр Хөгжлийн банкны талаар сэтгүүлчдийн асуусан асуултад “Хөгжлийн банктай холбоотой асуудлыг олон түмэнд ил тод зарлах ёстой. Хууль хяналтын байгууллага үүн дээр анхаарч ажиллах ёстой гэсэн шаардлагыг би хувьдаа өдөө ч тавьсаар байна” гэлээ.

ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



УИХ-ын гишүүн, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга **У.Таранжав**

“ᠨᠢᠵᠡᠭᠡᠢ ᠴᠣᠳᠠᠭᠠᠢ ᠶᠡᠭᠡ
 “ᠣᠶᠠᠭᠣᠳᠡ ᠠᠭᠠᠭᠠᠳᠡ” ᠨᠠᠢ ᠠᠭᠠᠳᠡ
 ᠠᠠᠢ ᠶᠡᠭᠡᠭᠡᠢ ᠠᠭᠠᠭᠠᠳᠡᠨᠠᠢ
 ᠠᠢ ᠣᠡᠳᠠᠭᠡᠨᠠᠢ ᠠᠣᠣᠳᠣᠣᠡᠳᠠᠭᠠᠢ
 135 ᠣᠶᠠᠭᠠᠣᠢ ᠣᠡᠳᠠᠭᠠ
 ᠴᠠᠳᠣᠣᠣᠡᠨᠠᠢ. Үᠢᠶᠢ ᠠᠨᠠᠳᠡ
 ᠡᠦ ᠢ ᠣᠢᠶᠠᠣ ᠠᠭᠠᠭᠠᠳᠡᠣ ᠣᠣᠠᠭᠠᠢ
 ᠠᠢᠡᠨᠢᠣᠳᠡ ᠡ ᠠᠠᠡᠶᠠᠭᠠᠢ ᠣᠠᠳᠠᠶᠡ
 ᠠᠠᠡᠶᠠᠢ.”

Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

Дугаарын **60** мөр

Элс, цасаа мөнгө болгоё

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт


Харин манайд Жак Матай адилхан хүүгээс ч илүү жуулчдын анхаарлыг татахуйц баялаг бий. Тэр бол говьд зүгээр л хэвтэж байдаг элсэн манхан, өвөлдөө ордог цас. Дэлхийд ердөө 13 оронд л өвөл болдог бөгөөд тэдний нэг нь Монгол. Өвөл болдоггүй, цасны тухай мөрөөдөхөөс хэтэрдэггүй орны шинэ содон зүйлсийг эрэн хайгч жуулчдыг татаж боломж манайд өгөгдсөн гэсэн үг. Хятадын эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө манайхаас ч илүү хүйтэн Харбин хот жилдээ 10 сая жуулчин хүлээн авч байхад, “цас мөсний орон” гэх тодотголтой Монгол улс жилдээ 400 хүрэхгүй мянган жуулчин хүлээн авдаг байх жишээтэй. Харбин хотын хувьд цас, мөсний үзэсгэлэнгээрээ тун ч их алдартай. Тус хотод жил бүр цас, мөсний үзэсгэлэн зохион байгуулагддаг бөгөөд бүр хоёрдугаар сар хүртэл үргэлжилдэг. Харин Сибирийн өвлийн аялалын тухайд олон улсын хэмжээний тэмцээн уралдааныг зохион байгуулж, түүгээрээ жуулчдыг татаж байх жишээтэй. Гэхдээ хамгийн анхаарал татахуйц нэг зүйл нь тэрхүү бүсэд дунджаар 10-20 мянган ам.доллар зарцуулан аялдаг жуулчдыг Хятад тэргүүлж, Япон удаалж, Америк гуравдугаарт бичигдэж байх юм. Хятад, Япончууд манайхыг алгасан алс холын мөсний ийнхүү зорьж байна. Хаяандаа байгаа тэдгээр жуулчдын сонирхолыг Монгол руугаа татахад хамгийн түрүүнд тээг болж буй хүчин зүйл нь сурталчилгаа муугийнх биш гэж үү. Морин чарган дээр дах нөмөрч, хөлдөө дэгтий углан, үнэгэн лоовууз тэргүүндээ залж тавьчихаад Хөвсгөл далайгаар аялж яагаад болохгүй гэж, эсвэл цаа буга унаж өвлийн баруун хязгаараар аялуулж ч болно шүү дээ. Жуулчид Монголыг онгон дагшин байгаль, уламжлалт зан заншлаар нь хүлээн авдаг. Бид ч гэсэн давуу талаа ашиглан, эдүгээ зүгээр л хэвтэж буй цас, мөс, элсэн манханаа “мөнгө болгоё”. Саудын Арабууд ч элсээ цас шиг л ашигладаг. Элсэн манхан дээгүүр сэндбордоор гулгахаас гадна моторт дугуй, ланд круйзер машинаар элсэн дээгүүр давхин дрифт хийхэд гайхалтай кайф авдаг гэнэ билээ. Манайд ч гэсэн элсэн манхан байдаг шүү дээ. Элсэн манхан дээгүүр шандаст хулгийн хурд мэдэн давхиж, тэмээ унаж, моторт дугуйгаар аялсан ч, нөөц нь манайд хангалттай бий. Гэвч үнэндээ сурталчилгаа алга. Жуулчны баазууд ч идэвхи чармайлт алга. Олон улсын аялал жуулчлалын томоохон үзэсгэлэнгүүдэд оролцдог ч, элс, цасаа сурталчлах тал дээр мариуухан байдаг бололтой. Тиймээс жуулчны баазууд, салбарын байгууллагууд жаахан идэвхи чармайлт гаргаж, сурталчилгаан дээрээ анхаарчихвал эдүгээ үнэгүйдэж буй цас, элсээрээ жуулчдыг татаж болох мэт. Манай улсын хувьд жилдээ аялал жуулчлалаас 131-150 сая ам.доллар олдог гэсэн баримт байдаг юм билээ. Харин элс, цас, мөсөө “мөнгө болгож” чадвал үүнийг хэд давсан их орлогыг олж чадах биш үү.

ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Энэ чинь одоо толгойтой бүхэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд байгаагаас ялгаа юу байна аа. Тиймээс хуулиа хурдан батал, гарга. 2005 оноос мөрдөгдөж байгаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль гарснаас хойш үр дүн гарсан гэж ярих хүмүүс ч байна. Мэдээж огт хуульгүй байснаас дээр нь тодорхой. Гэхдээ дан ганц шалдан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийг 10 гаруй жил хэрэгжүүлээ, юунд хүрэв. Харин ч гэр бүлийн хүчирхийлэл улам нэмэгдэж, бүрхэрцгийг хэлбэртэй болсоор байна. Тиймээс л шинэчлэн найруулж, асуудлыг шийдэж чадахаар хууль хэрэгтэй байгаа юм. Гэхдээ бас юманд учир, суманд гичир бийг эрх биш хууль санаачлагчид, батлах гэж байгаа гишүүд, ажлын хэсгийн мэдэх учиртай. Өнөө “Ардын элч” кинонд “Сайхан хүүхэн болгоныг бариад байх хэрэг үү” гэдэг шиг жаахан л юм болбол гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гээд л барьж аваад, шалгаад, шүүгээд л бөөн юм болох вий дээ. Ядаж байхад шартай эхнэртэй байж таараад, зүгээр шахуу байж байгаад бөөн төлбөр мөнгөнд унавал яана. Ингээд л гэр бүлийн харилцаа “будаа”. Хуулиа чангаруулж байгаа нь сайн л байна. Өмнө нь хуулийн дагуу хохирогч эвлэрэх шатанд гомдлоо татаж авсан тохиолдолд цагдаагийн хянан шийдвэрлэх ажиллагаа зогсдог байсан. Үүнээс болоод нөхөр нь эргэж өс санаж, эхнэрээ дахиж дарамталж, зодож, хүчирхийлэлд автуулдаг тохиолдол цөөнгүй байсан. Харин шинэ хуулиар бол хохирогч эвлэрч, гомдлоо татаж авсан ч мөрдөн байцаалт үргэлжлэх юм билээ. Нэг талаар зөв ч, нөгөө талдаа ганц удаагийн маргаан, хэрүүлээс болоод баахан цагдаа, шүүх дээрээ тулах вий. Ерөнхийдөө гишүүд, санаачлагч, ажлын хэсгийнхний ярьж, хэлснийг сонсоод, уншаад байхад шалгана, шүүнэ, торгоно, хорино гээд л байгаа. Уг нь Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг эхлэлтэй, давтамжтай байгаа. Дээрээс нь манай эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаагаа байдал зүйл мэтээр ойлгоод байдаг. Тиймдээ ч хүчирхийлэл үйлдэгч бараг л хийх ёстойгоо хийж буй мэт аашилдаг болдог байх. Тиймээс иргэдийн сэтгэхүй, сэдлийг өөрчлөх талын ажлыг маш сайн хиймээр байна. Ядаж л нийгмийн шинжтэй

ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ, ХҮМҮҮЖҮҮЛЭХ ХОЁРТ ЯЛГАА БИЙ ШҮҮ



ухуулах сурталчилгааг байнга явуулж, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд эхэлсэн даруйдаа тодорхой байгууллагад мэдэгддэг, цаашлаад хүчирхийлэл үйлдээд байгаа нөхрийг засч авах, сэтгэл зүйг өөрчлөх,

сургах чиглэлд анхаармаар байна. Нөгөө талаар эмэгтэйчүүд эдийн засгийн нөхцөл байдлаас үүдээд гэр бүлийн хүчирхийллийг шүд зуун тэвчдэг. Хууль чангараад, хүчирхийлэл үйлдэгчийг

бариад хорилоо, шийтгэлтэй гэж бодъё. Түүний цаана орх толгойлсон эмэгтэй үлдэнэ. Дагаад ядуу, дутуу амьдралтай нэг бүл гарч ирж байгаа юм. Тэглээ гээд хүчирхийлэгчийг дураар нь дургиул гэж байгаа юм биш. Энэ асуудлыг хуулинд

бас тусгаж өгч, гэр бүлийн хүчирхийллийн дарамтаас салсан ч эдийн засаг “гуай”-д дарамтлуулахаас төр аврах хэрэгтэй л гэж байгаа юм. Түүнээс гадна ажлын хэсэг хүүхэд хамгааллын асуудлыг нэлээд нарийн тусгаж өгсөн гэж яриад байна. Гэхдээ ямар зүйл, заалт тусгаж байгаа талаар тодорхой нарийн ярихгүй байгаа. Гэтэл зарим гишүүд өрнийн хуулийг хуулиа, хайртай хүүдээ гар хүрч болохоо болих нь уу гэж асуугаад, яриад байна. Дорнын ёс заншлыг ч бас хөндсөн. Мэдээж хүүхэд хамгааллын асуудлыг бид бүр тусад нь, илүү нарийн авч үзэх цаг болсон. Төрсөн эцэг нь, хойд эхийн хамтаар бяцхан охиныг яаж тамалж, амь насыг нь хөнөөлөө. Монголчууд мартаагүй л байгаа. Тийм жишээ, тийм жигшүүрт хэргийг олныг дурьдаж болно. Гэхдээ дайны хажуугаар дажин гэгчээр хэтэрхий сүржигнэх хүмүүс ч бас байна. Бараг л аав, ээж чинь загнавал утасдаарай гэх нь холгүй болчихсон. Тэр барууны оронд, нөгөө шүтээд байдаг Америкт нь л гэгдэг юм байгаа биз. Манайх бол арай өөр. Хүчирхийлэл үйлдэх, хүмүүжүүлэх хоёрын хооронд бас ялгаа бий шүү дээ. Бүр үгэнд орохгүй, сахилгагүйтээд байгаа хүүхдийн бөгсөн дээр нь ганц хоёр алгадаг нь байх л асуудал. Тэглээ гээд муудна гэж юу байх билээ. Гэтэл бөгсөн дээр нь ганц алгасаны төлөө хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн гээд байвал яах билээ. Миний хүүхэд учраас би зодох эрхтэй гэж дайрах хүн тийм ч олон гарч ирэхгүй байх. Гэхдээ хаа нэгтэй бөгсөн дээр ганц хоёр алгадаг эрх бол байх л ёстой болов уу. Энэ мэтийг сайн л бодолцоорой доо, эрхэм гишүүд, хууль санаачлагчид минь. Түүнээс биш нийгэмд хүлээлттэй байгаа, бушуухан баталчихъя гэж хандвал дараа нь гарах балаг их болчих вий. Дээрээс нь хөрөнгө мөнгөнийхөө асуудлыг сайн шийдэх хэрэгтэй. Үнэхээр төрөөсөө аврал хүсээд, хамгаалах байр хайгаад очиж байгаа иргэдээ өнөөдөр баттай хамгаалж чадаж байгаа бил үү. Чадахгүй л байгаа шүү дээ. Тэгсэн мөртлөө л баахан сүржин хууль яриад байдаг. Тэр нь ч мэдэгд, хөршүүд нь ярь, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэе л гээд хашгираад байгаа. Гэтэл 10, цаашлаад 20 хүн гүйгээд ирэхэд хамгаалж чадах чадамж Монголын төрд байгаа бил үү. Эхлээд санхүүгээ шийд. Тэгээд хамгаал.

УЛС ТӨР

УЛСТӨРЧ ЯРЬЖ БАЙНА

Н.УЧРАЛ:

НИЙГЭМД ОЮУН САНААНЫ ӨӨРЧЛӨЛТ АВЧРАХ “ОЮУНЫ ЭЛЧ”-ҮҮДИЙГ ШАЛГАРУУЛНА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Манай “Монголын залуу багш нарын холбоо” маань “Yes! Mongolia” гэсэн нэрийн товчлолтой. Энэ нэр ямар учиртай вэ гэхээр олон улсын NAFSA гээд Юнескод зөвлөх эрхтэй багш нарын байгууллага байдаг. Бид энэ холбооны Монгол дахь албан ёсны салбар гишүүн байгууллагын үүргийг гүйцэтгэдэг. Энэ утгаараа “Yes! Mongolia” гэдэг нэрийг өгсөн.

Холбоонд зөвхөн ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн багш нараас гадна цэцэрлэгийн багш нар хамрагддаг юм уу?

Дэлхийн бүх оронд оюун санааны гол төлөөлөгч нар гэж хэлж болох багш нар нийгмийн дуу хоолойгоо болон ажилладаг. Үүний дагуу бид Монгол Улсын 40-өөс доош насны багш нарыг энэ байгууллагадаа нэгтгэсэн юм. Тодруулбал, 40-өөс доош насны их, дээд сургуулиудын болон ерөнхий боловсролын сургуулийн, мэргэжлийн сургалт үйлвэрлэлийн төвүүдийн, сургуулийн өмнөх боловсролын буюу цэцэрлэгийн, Улаанбаатар болон 21 аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа сургалтын төвийн, залуусын эрүүл бие бялдартай фитнес клубуудын багш нар гэдэг маш олон салбарын багш нар манай холбоонд хамрагдаад явдаг. Энэ олон салбарын төлөөллийг багтаасан залуу сурган хүмүүжүүлэгчдийн холбоо гэж ойлгож болно.

Өнгөрсөн хугацаанд энэ холбоо хэр үр бүтээлтэй ажиллав аа?

Бид багш нарынхаа нийгмийн асуудлыг шийдэх олон асуудалд анхаарч ажиллаж ирсэн. Тухайлбал, нийслэлийн залуу багш нарын зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулсан. Түүнчлэн 1000 багшийн уулзалт, багш нараа сонсоё гэдэг аяныг улс орон даяар зохион байгуулж байлаа. Энэ бүх ажлын үр дүнгээ нэгтгээд, ер нь багш нарын дунд ямар, ямар асуудал тулгараад байгааг шигшин гаргаж тавьсан. Өөрөөр хэлбэл, залуу багш нар тулгамдаад байгаа 19 асуудлыг жагсаагаад, тухайн үеийн МАН-ын болон АН-ын бүлэг, Шударга ёс эвслийн бүлэгт албан бичгээр хүргүүлсэн байсан. Багш нар тулгамдаад байгаа эдгээр асуудлыг парламентад суудалтай болоод суудалгүй намуудын мөрийн хөтөлбөрт тусгасан байх ёстой гэдэг саналыг хүргүүлсэн юм. Энэхүү ажлын маань үр дүн ч гарсан. Тухайлбал, МАН-ын мөрийн хөтөлбөрт залуу багш нарыг дэмжих, цалин хөлс болон урамшууллын тогтоолдоог боловсронгуй болгох, үр дүнгээрээ буюу сурагчид болоод

эцэг, эхчүүдийн сэтгэл ханамжид тулгуурлан цалин хөлсний системийг нь шинэчлэх, багш нарын хөгжих бололцоог нь олгох, давтан сургах зэрэг олон асуудлыг суулгаж чадсан. Багш нарын болон боловсролын чиглэлийн олон санал, санаачилгуудыг маань МАН-ын бүлэг хүлээн аваад, энэ удаагийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч багш нарыг дэмжих асуудал бодитойгоор ороод, явж байгаад миний бие их баяртай байгаа. Ер нь цаашдаа залуу багш нарын холбоо үйл ажиллагаагаа илүү боловсронгуй болгож, багш нарын дунд тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэнэ. Түүнчлэн нийтлэг эрх ашгийг нь хамгаалахын төлөө олон олон ажлыг төлөвлөдөг байна.

Монгол Улсад залуу багш нарын холбоонд хамаардаг буюу 40-өөс доош насны хэчнээн багш байдаг юм бэ?

Одоогийн байдлаар манай улсын 40-өөс доош насны нийт 30 гаруй мянган багш байдаг гэсэн тоо баримт байгаа. Гэхдээ одоогоор эдгээр багш нараа албан ёсны гишүүнчилж, бүртгэл хийж амжаагүй л байна. Харин албан ёсоор 2000 гаруй багш л бүртгэлтэй байгаа. Одоо салбар зөвлөлдүүд шинэчлэн зохион байгуулж, хуралдуулах гэж байгаа. Тэгэхээр илүү багш нарын дуу хоолойг нэгтгэх болно. Тэгээд ч би төрийн эрх барих дээд байгууллагад ажиллаж байгаа учир багш нарын шаардлагуудыг тодорхой төвшинд нь сонсож, хүргэхийг нэлээд анхаарч ажиллана. Энэ хүрээнд ирэх 2017 онд Монголын залуу багш нарын анхдугаар их хурлыг зохион байгуулахаар төлөвлөдөг байна.

Залуу багш нарын холбооноос “Оюуны элч-2016” оны шилдэг залуу багшийг шалгаруулахаар болсон гэсэн. Энэ талаар мэдээлэл өгөөч?

Бид жил бүр оны шилдэг багш нарыг тодруулдаг уламжлалтай. Энэ жилийн хувь “Оюуны элч-2016” оны шилдэг залуу багшийг шалгаруулахаар болоод байна. “Оюуны элч” гэсний учир нь багш нараараа дамжуулан оюун санааны шинэ мэдээ, мэдээллийг түгээдэг, зөв үлгэр дуурайлал, зөв хандлагийг хүүхдүүдэд төрүүлэхийг зорьж байгаа.

“Оюуны элч”-ээр хэчнээн багшийг шалгаруулах юм бэ. Холбоонд багтдаг салбар бүрээс тодруулах уу. Эсвэл?

Салбар бүрээс тодруулахаар төлөвлөдөг байгаа. Тодруулбал, их, дээд сургуулиудын дундаас, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдээс, сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгүүдээс, сургалтын төвүүдээс олон хэмжээнд тус бүр нэг багш тодруулах юм. Тиймээс нийтдээ таван “Оюуны элч”-ийг тодруулах юм. Энэхүү “Оюуны элч” шалгаруулах арга хэмжээ

маань үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж байгаа. Тиймээс маш олон анкет, материал ирж байна. Энэ хүрээнд бид сонгон шалгаруулалтыг нэлээд өндөр төвшинд тавьж байгаа. Түүнчлэн бид оны шилдэг зарим багш нартаа холбооныхоо “Оюуны од” цол тэмдэгийг олгоно.

Салбар бүрээс элчүүдийг тодруулах юм байна. Тиймээс үүнийг дагаад шалгуур нь өөр, өөр байна биз дээ?

Мэдээж салбар бүрийн багш нарын шалгуур өөр байгаа. Нэр дэвшүүлэх багш нь сурган хүмүүжүүлэх салбарт гурваас дээш жил ажилласан, ажил мэргэжлийн үр чадвар, бүтээлч үйл ажиллагаагаараа бусдыгаа манлайлан ажилласан, хариуцсан ажлын үзүүлэлт сүүлийн 3-5 жилд улс, хот, аймгийн дундаж төвшнөөс дээшилсэн байна. Түүнчлэн сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны ажлын үр дүнгийн үнэлгээгээр “А” буюу хангалттай үнэлгээ авсан, дотоодын болон гадаадын эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд илтгэл тавьж, судалгааны ажил бүтээл гаргаж, мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байх, Монголын залуу багш нарын холбооноос зохион байгуулсан олон нийтийн ажлуудад амжилт гаргасан байх гэх мэт шалгуур байгаа. Түүнчлэн нийгэм олон нийтийн идэвхтэй оролцогч, санаачлагч, зохион байгуулагч байх, ажиллаж байх хугацаандаа ёс зүй, хэв журмын зөрчил гаргаагүй байх гээд шалгаруулах үндсэн үзүүлэлтүүдийн жагсаалтыг гаргахын байгаа.

Мэдээж монголын залуу багш нарын холбооны “Оюуны од” цол тэмдэг, “Оюуны элч” цомын эзэн болсон шилдгүүдэд нэлээд хариуцлага хамтдаа ирэх байх?

Тэгэлгүй явах. Бид “Оюуны элч” болох таван багшийг жил бүр шалгаруулж байхаар тохироод байгаа. Эдгээр таван элч 2017 онд бид бүхнийг төлөөлөх юм. Өөрөөр хэлбэл, эдгээр оюуны элчээрээ дамжуулан их, дээд сургуулиудынхаа оюутнууд болон багш нар цаашлаад нийгэмд оюун санааны өөрчлөлтийг хийхийг зорьж байна. Энэ мэт олон төлөвлөж байгаа ажил байна. Энэхүү арга хэмжээг нийслэлийн боловсролын газар хамтран зохион байгуулж байгаа. Түүнчлэн аймаг орон нутгийн болон дүүргүүдийн боловсролын хэлтсүүд хамтран, дэмжиж ажиллаж байна. Мөн БСШУСЯ биднийг дэмжиж байгаа.

Холбооныхоо салбар зөвлөлдүүд шинэчлэн зохион байгуулж, хуралдуулан гэж байгаа гэлээ. Үүнээсээ өмнө багш нараа сонсох аяныг дахиад зохион байгуулах уу?

Ер нь жил бүр “Багш нараа сонсоё” гэдэг аяныг оронд үргэлж



Гэрэл зургийг Г.АРТҮҮЖИИ

Гэхдээ салбар зөвлөлдүүд шинэчлэн зохион байгуулж, хуралдуулахын өмнө дахин энэ аянаа явуулах нь зөв байх гэж бодож байгаа. Салбар зөвлөлдүүдийг шинэчлэх, чуулгануудыг зохион байгуулж байгаа нь шинэ залуу багш нараар төлөөллөө нэмэгдүүлэх буюу цус сэлбэх зорилготой юм. Ялангуяа 22-24 настай, дөнгөж сургуулиа төгсөөд багшлах эрхээ аваад шинээр багш болж байгаа хүмүүсийг зөвлөлдөө оруулж, залгамж халаагаа бэлтгэхийг зорилго болгож байгаа. 40-өөс доош нас гэдэг бол хүний хамгийн идэвхтэй нас. Тэгээд ч багш нарын ихэнх нь 40-өөс доош насныхан болчихсон байгаа. Ер нь багш хүний нийгэм дэх нэр хүнд, үнэ цэнэ бага байдаг болсон. Учир нь тэдний нэр хүнд цалин хөлс, санхүүгийн асуудлаасаа болоод, уначихсан. Тэгээд ч багш нар таван жил тогтвортой ажиллаад овоо мэдлэгтэй чадвартай болоод ирдэг. Гэтэл таван жил ажилласан ч өнөөх цалин нь хэвээрээ л байдаг. Тиймээс ч олж авсан мэдлэг чадвартаа тулгуурлаад цалин өндөртэй гэж үзээд, хувийн компанийн менежер хийгээд явчихдаг жишээ олон байна. Энэ асуудлаас болоод чанартай багшийн асуудал хөндөгдөх болоод байгаа. Ялангуяа хөдөө орон нутгуудаас ийм гомдол санал их ирдэг. Тиймээс хүссэн ч хүсээгүй бид багш нараа дэмжих

ёстой. Өнгөрсөн хугацаанд манай холбоо 600 гаруй сургагч багшийг бэлтгэсэн. Эдгээр багш нар нь олон улсын сургагч багш гэсэн өргөмжлөлийг авсан. Энэ хүрээнд биш цаашдаа боловсролын газруудтай хамтраад, үндэсний хэмжээний сургагч багш нарыг бэлтгэхэд олон улсын хөтөлбөрүүдийг оруулж ирэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд нийслэлийн боловсролын газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг үзэглээд байгаа. Ер нь цаашдаа багш нарын дунд тулгамдаад байгаа давтан сургах, мэргэжлээ дээшлүүлэх, өсч дэвших бололцоонуудыг бий болгож өгөхийг зорин ажиллах болно.

Багш мэргэжлийн үнэ цэнийг нийгэмд нэмэгдүүлэхийн тулд юу хийх ёстой юм бэ?

Нийгмийн тэргүүлэх салбар болсон багш нарынхаа санхүүгийн болон нийгмийн баталгааны асуудлыг сайжруулах хэрэгтэй байна. Ялангуяа хүүхдүүдийн багш мэргэжлээр сурагдах эрмэлзлэлийг нэмэгдүүлэх хэрэгтэй байгаа юм. Тиймээс багш мэргэжилтэн бэлтгэж байгаа сургуулиуд үнэхээр чадвартай хүүхдүүдийг үнэ төлбөргүй сургадаг систем рүү шилжих шаардлагатай байна. Тэгэхгүй бол сүүлийн үед хүүхдүүд нийгэмд нэр хүнд нь уначихсан учир багш мэргэжлийг сонгохоо болиод байна. Тиймээс ч дунд сургуулиуд эхнээсээ багшгүй болоод эхэлж байна. Ер нь багш гэдэг мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх асуудал төр Засгийн бодлогын төвд байх асуудал юм.

Багшийн цалин нэмэх болон тэдний нийгмийн асуудлыг шийддэг байх талаар та хөндөж байсан байх аа?

Багш нар сардаа 480 мянган төгрөг гар дээрээ аваад, амьдарлаа залгуулаад явна гэдэг хүнд шүү дээ. Төсвийн асуудал хэлэлцэж байхад ч би хэлж л байсан. Бид өнөөдөр багш нарын цалин нэмж чаддаггүй юм бол нийгмийн асуудлыг нь шийдэх өгөх хэрэгтэй. Тухайлбал, багш нараа нийтийн тэвэрээр үнэ төлбөргүй явуулдаг болгох, багшийн хүүхдийг цэцэрлэгт хамгийн түрүүнд бүртгээд авчихдаг байх, багш нараасаа сонгон шалгаруулаад, магистр, докторын сургалтад нь тэтгэлгээр явуулдаг болж ягаад болохгүй гэж. Төрийн албан хаагчийн хүүхэд их, дээд сургуульд үнэ төлбөргүй суралцах зэргээр тэдний нийгмийн асуудлыг нь шийдэх шаардлага байна. Орон сууцжуулах хөтөлбөрт багш нарыг хамгийн түрүүнд хамруулж болох юм. Мөн багш нарт академик эрх чөлөөг олгох хэрэгтэй байна. Багш нар маш их цаас үйлдвэрлэж байгаагаасаа болоод, цагийн ачаалал асар их болдог. Уг нь академик эрх чөлөөг олгож чадвал их, дээд сургуулиудын багш нар үндсэн цагийн хичээлээ орчихоод бусад сул цагт нь хувийн болон бусад сургуулиудад цагаар багшлах, хуулийн чиглэлийн багш бол өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг байж болно. Дунд сургуулийн багш нарт ч гэрээр давтан сургах, хоцрогдол арилгах зэргээр олон боломж байгаа. Тиймээс энэ мэт эрх чөлөөг олгох л хэрэгтэй байгаа юм. Тиймээс өнөөдөр шууд багш нарын цалин нэмчж чадахгүй юм гэхэд энэ мэт гарцууд олон байгаа. Гэхдээ цаашдаа багш нарын цалин нэмэх зайлшгүй шаардлагатай.

Уг нь багш нар чинь зэрэг ахих хэрээр цалин нь нэмэгдэг биз дээ?

Багш нар зэрэг нь нэмэгдэхгүй л бол цалин нь нэмэгдэхгүй. Өөрөөр хэлбэл, зэргээс өөр цалингийн шатлал байхгүй. Гэтэл 480 мянган төгрөгийн цалинтай багш, амьдарлаа авч явхын зэрэгтээ давхар төлбөр төлөөд зэргээ дээшлүүлнэ гэдэг үнэхээр бэрх асуудал. Тиймээс өөр цалингийн шатлал буюу амжилтаар нь цалин нь нэмдэг байх хэрэгтэй. Хэрвээ тэгэж чадвал тухайн багш чадварлаг л бол зэрэг ахиагүй байсан ч 22 настайдаа багш болсон хүн 24 настайдаа амжилт гаргаад үнэлэгдэж болно. Өндөр цалин авдаг болно гэсэн үг. Гэтэл одоо амьдрал дээр олон олон амжилт гаргасан багш нарын цалин нэмэх гэхээр зэрэг нь ахиагүй байх жишээтэй. Тэгэхээр үнэхээр тухайн багшийн хүүхдүүд амжилт гаргаад, сурагчид болоод эцэс, эхийн сэтгэл өгөх хэрэгтэй. Тухайлбал, багш нараа нийтийн тэвэрээр үнэ төлбөргүй явуулдаг болгох, багшийн хүүхдийг цэцэрлэгт хамгийн түрүүнд бүртгээд авчихдаг байх, багш нараасаа сонгон шалгаруулаад, магистр, докторын сургалтад нь тэтгэлгээр явуулдаг болж ягаад болохгүй гэж. Төрийн албан хаагчийн

АН-ын гишүүдийг нэгдүгээр сарын 06-ныг хүртэл бүртгэнэ

Ардчилсан нам даргаа нийт гишүүдийнхээ оролцоотойгоор сонгохоор болсон. Намын даргын төлөөх сонгуульд саналын эрхтэй бүх гишүүд оролцох юм. Тодруулбал, жилийн татвараа намдаа төлсөн гишүүд саналыг эрхтэй байх аж. Тиймээс нийслэлийн Ардчилсан намаас гишүүдийн шинэчилсэн бүртгэл явуулахаар болсон талаар өнөөдөр мэдээллээ. Ардчилсан амын гишүүний шинэчилсэн бүртгэл, татвар төлөлт, нэгдсэн бүртгэлийг энэ сарын 12-ноос орон даяар эхлүүлсэн байна. Энэ ажлыг Ардчилсан намын Хэрэг эрхлэх газар хариуцаж байгаа аж. Шинэчилсэн бүртгэл хамрагдах Ардчилсан намын гишүүн иргэний үнэмлэх дээр байгаа хаягийнхаа дагуу харьяа нутаг дэвсгэрийнхээ анхан шатны байгууллагад бүртгүүлэх шаардлага тавьж байгаа аж. Ардчилсан намын Хэрэг эрхлэх газраас мэдээлж байгаагаар шинэчилсэн бүртгэл хамрагдах иргэд маягтын дагуу бөглөсөн өргөдөл, иргэний үнэмлэх, намын батлаг, 4x3 хэмжээтэй цээж зураг хоёр хувийг бүрдүүлсэн байх ёстой аж.

Мөн Ардчилсан намын гишүүний 2016 оны жилийн татвар болох 12 мянган төгрөгийг ХААН банк, АН-ын 5028701420 тоот дансанд тушаах юм байна. Ингэснээр Ардчилсан намын даргын сонгуульд оролцох эрх бүрдэх аж. Орон нутгаас болон хот дотроо шилжилт хийсэн намын гишүүн нэг сарын дотор харьяа намын хороондоо бүртгүүлэх ёстой аж. Намын гишүүний шинэчилсэн бүртгэл



Гэрэл зургийг Г.АРТҮҮЖИИ

болон, татвар төлөлтийн талаарх мэдээллийг 2017 оны нэгдүгээр сарын 06-ны өдөр хүртэл орон даяар авах юм байна. Сум хорооны үүрэгдээс ирүүлсэн баталгаажсан гишүүдийн бүртгэлийн материалыг аймаг, дүүргийн намын Хэрэг эрхлэх

газар 2017 оны нэгдүгээр сарын 08-ны дотор төв намд ирүүлэхээр заажээ. Харин Ардчилсан намын даргыг сонгох санал эрхтэй гишүүдийн нэрсийн жагсаалтыг 2017 оны нэгдүгээр сарын 29-ноос өмнө тус намын Хэрэг эрхлэх газар гаргах юм байна.

ОНЦЛОХ ХУУДАС

АМ.ДОЛЛАРЫН ХАНШ ӨССӨӨР БАЙХ УУ, БУУРАХ УУ

Эсрэг тэсрэг байр суурь

Н.Баяртсайхан:
Зэс, нүүрсний үнэ өсч байгаатай холбоотой боломжууд нээгдэж байна



/Монголбанкны Ерөнхийлөгч/

Бидний өдөр тутамд мөрдөж ажилладаг Монголбанкны тухай хуулинд Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийн бодлогыг хэрэгжүүлэхдээ ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх зарчим баримтална гэж заасан байдаг. Бидэнд төгрөгийн тогтвортой байдал болон эдийн засгийн тэнцвэртэй хөгжил маш чухал. Валютын асар их нөөцтэй улс оронд бол үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг тогтмол түвшинд барьж чаддаг. Гэхдээ одоогоор их ховор тохиолдол юм. Ихэнх улс оронд ханштай холбоотой асуудал үүсч л байдаг. Манай улсын хувьд мэдээж валютын нөөц хязгаарлагдмал, дээр нь зах зээлийн зарчимд тулгуурласан чөлөөт эдийн засагтай, хөрөнгийн урсгал хөдөлгөөн нь чөлөөтэй байдаг улс юм. Ийм нөхцөлд валютын ханшийг тогтмол барих гэж оролдох нь зөв бодлого биш. Ингэвэл байгаа гадаад валютын нөөцөө богино хугацаанд шавхаж дуусгахад хүрнэ. Энэ нь эцэстээ огцом савалгааг үүсгэж, эдийн засгийг хүчтэй уналтанд оруулах уршигтай. Тиймээс Монголбанк ханшийг тогтмол барих гэж оролдох нь оновчтой сонголт гэдгийг ойлгох хэрэгтэй. Харин богино хугацаанд үүссэн огцом савалгааг зогсоохын тулд шийдвэртэй арга хэмжээнүүдийг авсаар байх болно. Дээр нь 2017 онд Монголбанк валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлж, ил тод байдлыг хангасан шинэ тогтолцоо бий болгохын төлөө ажиллахаар зорьж байна. Энэ нь валютын ханш огцом савлаж эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. Үүний тулд мэдээж, хангалттай хэмжээний валютын нөөцтэй байх чиргатай. Ер нь валютын дотогшлох урсгалыг сайжруулах, эдийн засагт орох валютын хэмжээг нэмэгдүүлэхийг бүх л улс орон эрмэлздэг. Энд ширүүн өрсөлдөөн явагддаг. Дэлхий бол өрсөлдөөний том талбар. Манай орны хувьд экспорт бол валютын хамгийн том эх үүсвэр. Үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлж, аялал жуулчлалаа сайжруулвал боломж бий. Үүнээс гадна хөрөнгө оруулагчдад мөнгөө барьж ирээд бизнес хийх таатай орчныг бүрдүүлж өгөх нь валют олох бас нэг чухал суваг юм. Мөн хямд зээл авах, санхүүгийн зах зээлээс мөнгө татах арга байж болно. Нөгөө талаар бодлогын хүүгээ нэмсэн буруу гэх шүүмжлэлийг ойлгож хүндэтгэж байгаа. Нээлттэй нийгэмд шүүмжлэл сонсогддог хэн байх билээ. Энэ шийдвэр бол валютын нөөцөө л хамгаалах арга гэдгийг онцлох нь зүйтэй. Бид байгаа нөөцөө хямгадах, хамгаалах хэрэгтэй болсон. Монгол Улс 2017 онд нэлээд хэмжээний гадаад өр төлбөр барагдуулна. Нөөцтэй байх хэрэгтэй биз дээ? Нөгөө талаар Монгол төгрөгийн үнэгүйдлийг зогсоох, төгрөгийн үнэ цэнтэй мөнгө байлгах алхам байсан. Төгрөг бол үнэ цэнтэй мөнгөн тэмдэгт байх ёстой. Бодлогын хүүг өсгөсөн нь нэг талдаа төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлж, харин нөгөө талдаа валютын хадгаламжийг хязгаарлах зах зээлийн зарчимд суурилсан арга байсан. Монголбанк валютын нийлүүлэлт хийж байгаа, худалдан авалт ч бас хийж байна. Долоо хоногт хоёр удаа валютын дуудлага худалдааг Төв банк явуулдаг. Эрэлт хэрэгцээнээс хамаарч долоо хоногт 30-70 сая ам.доллар гаргадаг. Түлш шатахууны болон Монгол улсад зайлшгүй шаардлагатай бусад чухал бараа бүтээгдэхүүний импортын хэрэгцээг хангахад юуны түрүүнд анхаарч ажиллалаа. Харин сүүлийн үед гарч байгаа нэг сайхан хандлага бол банк, аж ахуйн нэгжүүд валютгаа бидэнд худалдаж эхэлсэн явдал. Хувийн хэвшлийнхэн маань амаргүй хүнд нөхцөл байдлыг ойлгож, хамтдаа даван туулах алхамаа ийн эхлүүлж байгаад талархаж байна. Энэ бол яах аргагүй эх оронч сэтгэлийн илэрхийлэл гэж хувь хүнийхээ зүгээс үзэж байна. Нөгөө талаар манай экспортод жин дардаг зэс, нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр өсч эхэлсэнтэй холбоотой боломжууд нээгдэж байна.

...Үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлж, аялал жуулчлалаа сайжруулвал боломж бий. Үүнээс гадна хөрөнгө оруулагчдад мөнгөө барьж ирээд бизнес хийх таатай орчныг бүрдүүлж өгөх нь валют олох бас нэг чухал суваг юм. Мөн хямд зээл авах, санхүүгийн зах зээлээс мөнгө татах арга байж болно...

...Гадаад зээлийн дарамт багасгал, валютын нөөц бүртгэл, төсвийн алдагдал тэглэлтэй төгрөг унасаар байх болно. Гол нь төв банкны мөнгөний, ханшийн бодлого зөв болтол ханш унасаар байх болно. Миний хувьд валютын нөөцгүй байгаа энэ үед валют, алт хоёр дээр онцгой зохицуулалт хийе гэсэн санал дэвшүүлж байгаа юм...



Н.Дашзэвэг:
Гадаад зээлийн дарамт багасгал төгрөг унасаар байх болно

/Эдийн засагч/

Ханш тогтворжлоо гэдэг нь түр зуурын үзэгдэл байх аа. Гадаад зээлийн дарамт багасгал, валютын нөөц бүртгэл, төсвийн алдагдал тэглэлтэй төгрөг унасаар байх болно. Гол нь төв банкны мөнгөний, ханшийн бодлого зөв болтол ханш унасаар байх болно. Миний хувьд валютын нөөцгүй байгаа энэ үед валют, алт хоёр дээр онцгой зохицуулалт хийе гэсэн санал дэвшүүлж байгаа юм. Ингэвэл төгрөгийн ханш уналт их хэмжээгээр явагдаж буй нь зогсоно. Валютын наймаачид, арилжааны банкууд ашиг олох гээд дураараа ханш тогтоож буйг болуулмаар байгаа юм. Монголын олборлож буй алт 15 тонн уу, 30 тонн уу гэдгийг төр засаг хянаж чадахгүй байгаа юм. Ялангуяа валютын нөөцгүй энэ үед ийм байж болохгүй.

Сэтгүүлчийн дүгнэлт

МОНГОЛБАНКНЫ БУРУУ, ҮГҮЙ ЗАСГИЙН ГАЗРЫНХ

Н.ПУНЦАГБОЛД

Ам.долларын ханш арваннэгдүгээр сард гэнэт огцом савлаж, зарим нэг хүн цус харвах дөхсөн. Тэр дундаа ам.долларын зээлтэй аж ахуйн нэгжүүдийн зүрхэнд шар ус хуруулсан болов уу. Гэхдээ л гэнэт дээшээ хөөрсөн ам.долларын ханш одоогоор 2500 төгрөг хавьцаа тогтоод байна. Гэхдээ энэ бол тийм бага ханш биш шүү дээ. Ам.долларын ханш 2000 төгрөг боллоо, юу болоод байна, аюулын харанга дэлдлээ гээд л саяхан амтай болгон хашгирч байсан. Гэтэл өнөөдөр 2500 төгрөгт хүрчихлээ. Бүр 3000 руу гэтэж байсныг эс тооцвол арай л дээр гээд л сууж байх уу. Энэ Монгол Улсад эзэн гэж байна уу энэ чинь. Асуудлыг хэн шийдэх ёстой вэ. Ажлаа хийж, асуудлаа шийдэх ёстой хүмүүс нь хуралдаа ч суухгүй, хувийн ажлаа хөөцөлдөж, "хор"-оо найруулж гүйцгээгээд л. Ард нь ард түмэн "ноён ногоон"-д дарлуулж, аж ахуйн нэгжүүд хаалгаа барихад хүрч байна.

Засгийн газар нь Монголбанк руу буруугаа чихнэ. Төв банк буцаагаад Засгийн газар ажлаа хийхгүй байна гэж зовлон тоочино. Нэг иймэрхүү л байдалтай өдөр хоногийн өнгөрөөж байна. Одоо бид ам.долларын ханш 2500 төгрөг хавьцаа тогтоож байгаад баярлаад суух ёстой болох нь. Төв банкинд үнэндээ бодлогын хүүгээ нэмэх, интервенц хийхээс өөрөөр ам.долларын ханшийг хазарлах арга байхгүй. Ядаж байхад валютын нөөц нэг тэрбум руу ороод ирлээ. Одоо үүнээс цааш нөөцөө буулгах арга Монголбанкнд байхгүй болсон. Арваннэгдүгээр сард 650 сая ам.долларын өртөг 17 тонн алт зарсан байсан. Удахгүй мөнгө болоод, валютын нөөц дээр нэмэгдэх байх. Тэгвэл зах зээлд ам.доллар нийлүүлж, ханшийг нь жаахан буулгах гэж оролдож магад. Гэхдээ 2016 онд аль хэдийнэ 1.291 тэрбум ам.доллараар интервенц хийчихээд байгаа. Үр дүнд ам.доллар 2500 төгрөг дээр тогтоож байх шиг байна.

Өөрөөр яах ч билээ. Өчигдөр төв банк бодлогын хүүгээ нэг нэгжээр буулгаж, 14 хувь болголоо. Ингэсгээд л тэдний хийх ажил дуусч байгаа юм. Харин Засгийн газар өнгөрсөн хугацаанд юу хийв. УИХ юу хийж амжуулав. Төв банк руу баахан дайрсан гишүүд л байгаа. Өөрөөр юу ч хийгээгүй. Өнөөдрийг болтол манай улсын томоохон төслүүд хөдлөх эсэх нь таамаг хэвээр байна. Ганц нэг уулзалт хийсэн болоод байж байгаа. Ер нь Засгийн хийж цөөн хэдэн ажлын үр дүн тодорхой биш. Бүтэх ч юм уу, бүтэхгүй ч юм уу, бүү мэд. Тэгээд чаддаг нь төв банк руу дайрах л болчихсон. Яриа хэлэлцээрээ хурдан хийгээд, үр дүн байдаг бол үзээч ээ, нөхөд өө. За тэр гаднаас зээл авах, ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах энэ тэр бол манайхаас хамаарахгүй л байх. Хүлээх ёстой бол хүлээж л таарна. Харин тэр нүүрсээ зарах, алтаа ухах гээд манайхаас илүүтэй хамаарах ажлаа жаахан түргэлчихвэл яасан юм бэ. Нэг л их худлаа ард түмэндээ хайртай царайлсан, шударга ёс ярьсан, зурагтаа гарахдаа уран цэцэн үг хэлсэн хүмүүс л байх юм. Тэгж байх зуур чинь төгрөг цаас болж, ам.доллар манайхыг эзэллээ байна.

Л.Оюун: Интервенц хийгээд ут хугацаандаа үр дүнгээ өгөхгүй



/МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн хөтөлбөрийн багш, доктор/

Төгрөг, долларын ханшийг зохицуулдаг нэг арга нь интервенц шүү дээ. Интервенц нь Ревальвацци, Девальвацци гэж хоёр хэлбэртэй байдаг. Ревальвацци нь төгрөгийнхөө ханшийг зориудаар өндөр болгож, эсрэг талд нь долларын ханшийг буулгах арга хэмжээ. Үүний гол хэрэгсэл нь бол зах зээлд долларын нийлүүлэлтийг нэмдэг. Үр дүнд нь валютын нийлүүлэлт нэмэгдэж, үүнийг дагаад ханш нь буудаг. Энэ аргыг хэрэглэж байна л даа. Гэхдээ энэ арга нь дунд болон урт хугацаандаа үр дүн өгөхгүй. Ер нь Монгол Улсад доллар төгрөгтэй харьцах ханшийг тогтвортой байлгах бодлого барья гэвэл өөр арга хэрэглэх хэрэгтэй. Нэгдүгээрт, долларын нийлүүлэлтийг дотоодоо оруулж ирэх хэрэгтэй. Үүнийг оруулж ирдэг ганц суваг нь экспортоо нэмэгдүүлэх. Түүнээс Монголбанк шиг зүгээр л зах зээлд доллар нийлүүлээд ханшийг тогтворжуулна гэж байхгүй. Энэ түр зуурын гал унтраах л арга. Хоёрдугаарт, Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, импортын бараагаа бууруулах арга. Ингэхийн тулд импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байгаа юм. Нөөц нь байсаар байтал бид эцсийн бүтээгдэхүүнийг өртөг өндөртэй авсаар байна шүү дээ.

УЛС ТӨР



АН-ЫН ДАРГАД НЭР ДЭВШИГЧИД ҮНЭМЛЭХЭЭ ГАРДАЖ АВЛАА

Гэрэл зургийг Г.АРТУУЖИП

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Сонгууль явуулахад зардал гарах нь тодорхой. Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулахад 10-15 тэрбум төгрөг зарцуулагддаг. Бид байдаг бүх зардлаа хасаад энэ удаад 1.5-2 тэрбум төгрөгт багтаахаар төлөвлөсөн. Үүнийг иргэд ойлгож байгаа. 2020 оны амжилт өнөөдрөөс эхэлнэ. Хариуцлагатай байгаарай. Хэн нь ч ялсан, хэн ялагдсан ялсан даргадаа амжилт хүсээд хамтран ажиллаарай. Нэр дэвшигч буй таван эрхэмдээ амжилт хүсье!" гэлээ. Мөн тэрээр "Улс төрийн өрсөлдөгч МАН-ынхан манай намын даргын шинэчлэлд их санаа зовж байна. Төрийн эрх барьсан та нарт толгойтой үснээс их ажил байгаа. Манай намын сонгуулиас хол бай. Утаагаа алга болго оо. Та нартай, та наргүй бид болчихно" хэмээн сануулаад авлаа. Ийнхүү намын даргын сонгуулийн

сурталчилгаа албан ёсоор өчигдрөөс эхэлж байна. Сонгууль нэг сарын турш үргэлжилж, 2017 оны нэгдүгээр сарын 19-нд өндөрлөх юм. Шинээр сонгогдсон намын даргаа долдугаар Их хурлаараа батламжлах билээ. Ардчилсан намын даргад нэр дэвшигчдийн сурталчилгаа арванхоёрдугаар сарын 22-нд Хэнтий аймгаас эхлэхээр болж, маршрут нь гарчээ. Үүний дараа нь Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Говьсүмбэр аймгуудад очиж, нэр дэвшигчийн сурталчилгаагаа үргэлжлүүлэх юм байна. Дараа нь нийслэлийн есөн дүүрэгт ажиллах бол сурталчилгааны хаалт нь Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт таарч буй аж. Гэхдээ явцын дунд мөн өөрчлөлт орж мэдэх юм байна. Энэ талаар АН-ын даргын сонгуулийн хорооны дарга Ж.Оюунбаатар "АН-ын VI их хурлаас намын дүрэмд өөрчлөлт оруулсан. Дүрэмд орсон заалтад АН-ын даргын сонгуулийг орон даяар зохион байгуулна гэж заасан.

Дүрмийн дагуу хандивын мөнгийг сонгууль зохион байгуулалтын болон сонгуулийн сурталчилгааны зардал гэж хоёр хуваасан. Сонгуулийн зардлыг нэр дэвшигчдэд ижил хэмжээтэй хувааж тооцно гэсний дагуу 1.2 тэрбум төгрөгийн зардлыг хувааснаар нэр нэр дэвшигч 240 сая төгрөг хандивлана. Дүрмийн дагуу 200 сая төгрөгөө өгсөн таван нэр дэвшигч 40 сая төгрөг нэмж өгнө. Сонгуулийн сурталчилгаа нэгдсэн нэг журмаар явна. Бүх нэр дэвшигчид хамтдаа аймаг, дүүрэг орон нутгаар нэг цаг хугацаанд сурталчилгаа хийнэ. Бусдаасаа салангид, бие даасан сурталчилгаа хийхийг дүрмээр хориглосон байгаа. Сурталчилгааг арванхоёрдугаар сарын 22-нд Хэнтий аймгаас эхлүүлж, улс орон даяар нэгдсэн журмаар зохион байгуулна. Улмаар ирэх оны нэгдүгээр сард болох АН-ын даргын санал хураалтаас өмнө намын шинэчилсэн бүртгэлийг хийж байна. Энэ шинэчилсэн бүртгэлийг цахимаар

хийж байгаа. Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан намын татвараа төлсөн бүх гишүүд саналаа өгнө. Өөрөөр хэлбэл, намын дүрмийн дагуу нэг жилийн 1200 төгрөгийн татвараа төлсөн, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан намын гишүүд намын даргын сонгуульд саналаа өгнө. Одоо албан ёсоор 180 мянган гишүүнтэй байгаа. Намын даргын сонгуулийн хажуугаар намынхаа гишүүдийн бүртгэлийг цахимжуулах, шинэчлэх том ажлыг давхар хийж байна" гэлээ. Нэр дэвшигчид үнэмлэхээ гардан авсаны дараа үг хэлж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан юм. Үүний дараа АН-ын дарга З.Энхболд эвтэй байхыг бэлэгдэж нэр дэвшигчдэд багцалсан таван сум гардуулсан. Улмаар Чингис хааны хошоонд хүндэтгэл үзүүлснээр Ардчилсан намын даргад нэр дэвшигчдийн үнэмлэхийг гардуулах ёслолын ажиллагаа өндөрлөсөн юм.

Нэр дэвшигчид үнэмлэхээ гардсаныхаа дараа сэтгэгдлээ илэрхийлсэн юм.

С.Эрдэнэ: Нэр дэвшигч байгаа журмын нөхөддөө амжилт хүсье

/УИХ-ын гишүүн, АН-ын даргад нэр дэвшигч/

-Нэр дэвшигч байгаа нөхдөө миний хамтран зүтгэгч гэж харж байгаа. Ардчилсан намыг байгуулсан цагаас хойш 26 жилийн түүхэнд энэ намын алдах, онох, бүхий л жаргал зовлонг хамтдаа үүрч явсан журмын нөхөдтэйгээ намын даргын сунгаанд явж байна. Энэ сунгааг дотоодын өрсөлдөөн гэж битгий хараасай гэж хүсч байна. Энэ бол шинэчлэлийн төлөө оруулж байгаа хувь нэмэр гэж хараасай. Тийм учраас АН-ын мянга мянган гишүүд нийт ард иргэд маань бидэнд тэгш, шударга хандаасай. Бүхий л үйл ажиллагаанд бүх шатны намын байгууллагууд шударгаар ажиллаасай. Журмын нөхөддөө амжилт хүсье. Миний хувьд өнөөдөр хэн ч ялсан бай АН-ынхаа шинэчлэлийн төлөө намынхаа ирээдүйн амжилт, ялалтын төлөө, эх орныхоо сайн сайханы төлөө зүтгэх учиртай.

Д.Эрдэнэбат: Даргын сунгаад оролцох эсэхдээ их эргэлзэж байсан

/УИХ-ын гишүүн, АН-ын даргад нэр дэвшигч/

-Миний хамтрагч, энэ намын жаргал зовлонг хуваалцагч, АН-ын нүүр царай болж байгаа хүмүүстэй намын даргын төлөө өрсөлдөж байна. Даргын сунгаанд оролцох уу, үгүй юу гэдэгт хувь хүнийхээ хувьд маш их эргэлзэж байсан. Гэхдээ намын гишүүд дэмжигчид "Д.Эрдэнэбат аа, чи намын даргын сунгаанд оролцох чинь намын нэр хүндийн асуудал шүү" гэдэг шаардлагыг тавьсан учраас даргын сунгаанд оролцож байгаа юм. Ардчилсан төрийн баталгааг хангах, АН-ын шинэчлэлийг цоо шинэ төвшинд гаргах ажлын эхлэл учраас энэ сонгуульд би оролцож байгаа юм. 2016 оны УИХ-ын сонгуулийн ялалт энэ намыг цааш хэрхэн авч явах вэ гэдэг дохиог бидэнд өглөө. Сонгуулийн маргаашнаас намын нүүр царай өөрчлөгдөж, бид эв нэгдэлтэй, бие биенээ дэмжсэн бодлоготой, харуцлагатай нам болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Л.Гантөмөр: Намын даргын өрсөлдөөн итгэлийг сэргээсэн үйл ажиллагаа болоосой

/УИХ-ын гишүүн асан, АН-ын даргад нэр дэвшигч/

-АН-ын даргын сонгуулийн ажлыг зохион байгуулахад асар их зардал гарч байгаа. Энэ зардлыг хуваалцсан журмын олон нөхөддөө талархаж байна. УИХ-ын сонгуулийн их ялагдлын дараа АН-ын гишүүн бүр нэгийг бодож, хоёрыг тунгаасан. АН-ын 180 гишүүн хэлэлцэж байгаад намаа шинэчлэх хэрэгтэй гэж үзсэн. Зургадугаар их хурал хоёр том шийдэлд хүрсэн. Нэгдүгээрт, АН-ын шат шатны дарга нар намынхаа гишүүдээс сонгогддог байх, хоёрдугаарт, АН-ын шинэчлэлийн хөтөлбөрийг баталсан. Энэ удаагийн намын даргын өрсөлдөөн АН-ын гишүүдийн итгэлийг сэргээсэн үйл ажиллагаа болоосой гэж хүсч байна. Хүний нөөцийн зөв бодлоготой, эв нэгдэлтэй нам болж чадвал бид ирэх сонгуулиудад амжилт гаргаж чадна. Улс төрийн нам бол үзэл бодлын уралдааны талбар юм гэдэг итгэл үнэмшлийг ард түмэнд эргүүлж авчрах том боломж юм.

Ж.Бантзандан: Монголыг шинэчлэх ёстой учраас АН шинэчлэгдэх ёстой

/УИХ-ын гишүүн, АН-ын даргад нэр дэвшигч/

-АН яагаад шинэчлэгдэх ёстой вэ гэж олон хүн асууж байгаа. Монголыг шинэчлэх ёстой учраас АН шинэчлэгдэх ёстой. АН-ын шинэчлэл юу руу чиглэх вэ гэж олон хүн анхааралтай харж байгаа. Өнгөрсөн найман жил АН хаалттай нам байсан. Одоо үүнийг эцэс болгоё. АН шинэчлэгдэе гэж байгаа бол бүх үүд, цонхоо ард түмэндээ нээх хэрэгтэй. Мөн үзэл санааны шинэчлэл хийх хэрэгтэй байна. АН эрх чөлөө, шударга ёс, хүний эрхийн төлөө нам байх ёстой. АН бүлэглэл, фракцын гарт орсон нам байх уу, ард түмний нам байх уу гэдгийг энэ шинэчлэлээр бид шийднэ. Таван фракцид хуваагдсан, таван өөр тийшээ харсан 10 бүлэглэлд үйлчилдэг явцуу эрх ашгийн нам байж болохгүй. Бид бүлэглэлд биш бүх гишүүдээ үйлчилдэг нам байх ёстой. Явцуу эрх ашгийн фракциудад хуваагддаг биш.

Н.Алтанхуяг: АН-ын даргыг сонгох ажил нийт монголчуудын асуудал

/Ерөнхий сайд асан, АН-ын даргад нэр дэвшигч/

-Намын даргын сунгаанд өрсөлдөж байгаа таван хүн 2012-2016 оны УИХ-ын нэг ангийхан. Намын даргын сунгаанд нэр дэвших шийдвэрийг би их тунгуу гаргасан. АН-ыг зургаан жил удирдсан учраас энэ удаагийн намын даргын сунгаанд оролцохгүй байа гэдэг байр суурьтай байсан. Гэсэн ч хойшуулж боломгүй харуцлагатай цаг үед нэр дэвших шийдвэрийг журмын нөхдийнхөө санал хүсэлтээр гаргалаа. АН-ын даргыг сонгох энэ ажил ганц манай намын дотоод асуудал биш. Нийт монголчуудын асуудал. АН-ынхан бид орон сууц, зам барилга, жижиг дунд үйлдвэрлэл гээд урьд өмнө нь байгаагүй том бүтээн байгуулалтыг хийж чадсан. Хууль эрх зүй, боловсрол нийгмийн халамжийн салбарт шинэчлэл эхлүүлж чадсан. АН засаглаж чаддаг гэдгээ харуулсан. Засаглахдаа ард түмнийхээ төлөө амаар биш ажил хэргээр засаглаж чаддагаа харуулсан.



ДЭЛХИЙ

Алеппо хотын иргэдийг нүүлгэх ажиллагаа дахин бүтэлгүйтлээ

Алеппо хотын зүүн дүүргээс иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг түр хугацаанд зогсоосон байсан билээ. Улмаар иргэдийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг дахин зохион байгуулж эхэлсэн хэдий ч, босогчид хэлэлцээрийн заалтаа зөрчин, энгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд хэрэглэж байсан автобус руу халдсаны улмаас дахин зогсчээ. Тодруулбал, босогчид болон Засгийн газрын хүчнийхэн хоёр ч удаа зөвшилцсөн ч, тохиролцоо амжилт олсонгүй. Бүслэлтэд байгаа хэдэн зуун мянган иргэний дунд хүүхэд эмэгтэйчүүд, шархадсан хүмүүс олноор байгаа тул тэднийг хотын сүйдсэн хэсгээс нэн яаралтай нүүлгэн шилжүүлж, хоол хүнс, эм тарианы тусламж үзүүлэх хэрэгтэй байгааг олон улсын байгууллагаас талуудад уриалж байгаа. Энэ хүрээнд хоёр тал зөвшилцсөн ч, бодит байдалд биеллээ олохгүй байгааг эх сурвалж онцолж байна. Уг нь өнгөрсөн пүрэв гарагт сөргөлдөгч талууд гал зогсоох гэрээ байгуулснаар иргэд төдийгүй босогчдыг хотоос нүүлгэн шилжүүлж эхэлсэн байдаг.

Гэвч тэднээр дамжуулан зэр эвсгээ гадагш гаргах оролдлого гарсны улмаас Засгийн газар нүүлгэн шилжүүлэлтийг түр зогсоогоод байв. Харин дараа нь Туркийн зуучлалаар дахин хэлэлцээрийн ширээний ард сууж, түр гал зогсоох хэлэлцээрийн хугацааг сунгасан, мөн л босогчид хэлэлцээр зөрчин автобус руу халджээ. Гэхдээ энэ хугацаанд 9000 иргэнийг аюулгүй газар руу амжиж нүүлгэсэн тухай албаны эх сурвалжууд мэдээлж байна.

Нэр өөрчлөв

Улсын бүртгэлийн 120127068 дугаартай "Есүхэйн төмөр" ХХК нь нэрээ өөрчилж "Отгон эсү" ХХК болон өөрчлөгдөж байгаа болно. Мөн Зундуй овогтой Чимгээ захиралыг Дагвасүрэн овогтой Эрдэнэ-Очир болгон өөрчлөв.



Пак Гын Хед ХОЛБОГДОХ ХЭРГИЙН АНХНЫ ШҮҮХ ХУРАЛ БОЛЛОО

Б.ДАВААХҮҮ

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн дотны найз Чой Сун Шил авлигын хэрэгт сэжиглэгдсэнээс хойш тус улсын улс төрийн салбарт эмх замбараагүй байдал үүссэн билээ. Чой Сун Шилийн Ерөнхийлөгчтэй дотно байдлаа ашиглан томоохон корпорациудаас өөрийн байгуулсан сандаа их хэмжээний мөнгийг хандив нэрийдлээр авч байсан нь илэрсний зэрэгтээ Ерөнхийлөгч Пак улс төрийн чухал баримт бичгийг найздаа дамжуулж, хэлэх үгээ зааварлуулж байсан нь баримттайгаар илэрсэн. Үүний дараа Ерөнхийлөгч өөрийн биеэр ард иргэддээ хандсан гурван удаагийн мэдэгдэл хийж, толгой бөхийлгөн уучлал хүссэн ч тусыг эс олсон юм. Пахын нэр холбогдсон дуулианыг сөрөг хүчнийхэн ч ашиглаж, өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа буухыг Ерөнхийлөгчөөс шаардаж, олон тооны ардиргэдийг хамарсан эсэргүүцлийн жагсаалыг зохион байгуулсан байдаг.

Мөн Пак Гын Хед итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулах үндэслэлийг парламентад өргөн барьсан удаатай. Харин Ерөнхийлөгч өөрийнх нь хувь заяа хэрхэхийг парламентын гишүүдэд даалгасан ч тэдний ихэнхи нь эсрэг сонголтыг хийснээр Пак суудлаасаа бууж магадгүй болсон билээ. Түүнийг албан тушаалаас нь бүр мөсөн огцруулах асуудлыг 180 хоногт багтаан Үндсэн хуулийн шүүх

шийдвэрлэх учиртай. Тэгвэл энэ хэрэг мандсанаас хойшхи анхны шүүх хурал өчигдөр Сөүлийн шүүх танхимд боллоо. Прокуроруудын хувьд Ерөнхийлөгч Пак Гын

...“Ердөө Ерөнхийлөгчийн үгийг л байгууллагуудад дамжуулсан төдий” гэж хариулжээ. Нөгөөтэйгүүр, Ерөнхийлөгчийн бодлого зохицуулалтыг хариуцсан Ерөнхий нарийн бичгийн дарга асан Ан Чон-Бумын өмгөөлөгч түүний үйлчлүүлэгчид тулгаж буй төрийн албаны нууц мэдээллийг задруулсан гэх хэргээ хүлээж байгаагаа мэдэгдсэн байх юм...

Хег Чой Сун Шил нарын сэжигтнүүдийн хамсаатан гэж үзэж буй бол Пакийн хувьд уг мэдээллийг эрс үгүйсгэж байгаа. Тиймдээ ч энэ удаагийн шүүх

хурлаар тодорхойгүй байгаа энэ мэт асуудлын учиг тайлагдаж магадгүй гэх таамгийг олон улсын ажиглагчдын зүгээс дэвшүүлж байлаа.

Шүүх хуралд Пактай 40 гаруй жил найзалсан Чой Сун Шил хар өнгийн хүүрээ бүхий нүдний шил үүж ирсэн байжээ. Түүний хувьд аравдугаар сарын 31-нд баривчлагдсанаасаа хойш анх удаагаа олон нийтийн өмнө ил гарсан нь энэ байв. Өмгөөлөгчдийн хэлж буйгаар тэрбээр энэ удаагийн шүүх хуралд заавал оролцох шаардлагагүй байсан ч, өөрийн хүсэлтээр ирж оролцсон гэнэ. Мөн энэ үеэр “Асуудал үүсгээнд уучлаарай, шүүн таслах ажиллагаанд би өөрийн биеэр оролдох болно” гэж хэлжээ. Дэлхий нийт ч БНСУ-ын шүүх байгууллага уг хэргийг хэрхэн шийдвэрлэхийг анхааралтай ажиглаж байна. Ямартай ч, 2014 оны Сөвдхөлтийн осолтой холбогдуулан 300 гаруй хүний амийг санамсаргүйгээр хөнөөсөн гэх хэргээр яллагдсан Сөвдхөлтийн багийнхны шүүх хурлаас хойшхи олон нийтийн анхаарлыг татсан дуулиант хурал нь энэ байлаа. Баривчлагдах үедээ Чой хэвлэлийнхэн болон эсэргүүцэгчдийн улмаас парадгийн өрөөсөн гутлаа гэж байсан бөгөөд тухайн үед бүсгүй “үхэх нүгэл үйлдсэн” хэмээн хэргээ хүлээж байсан гэнэ. Шүүх хурал хэр удаан үргэлжлэх нь тодорхойгүй байгаа юм. Гэхдээ хуулийн хугацаа буюу зургаан сарын дотор багтаан хэргийг шийдвэрлэх учиртай. Чойг

Ерөнхийлөгчтэй дотно байдлаа урвуулан ашиглаж авлига авсан гэх хэрэгт буруутгаж буй. Хэрэв түүнд ногдуулж буй бүх үндэслэлээр яллавал шоронд 15 жил хорих ял сонсч магадгүй гэнэ.

Харин баривчлагдахынхаа өмнө Чой Пакийн илтгэлийнхээ үеэр хэлэх зарим үгийн материалыг хүлээн авч байсан ч, улс төрийн нууц мэдээлэл байсан эсэхийг нь мэдэхгүй хэмээж байжээ. Мөн түүнд тулгаж буй бусад үндэслэлийг ч үгүйсгэж байгаа аж. Мөн энэ шүүх хуралд Пакийн хоёр туслах нь холбогдсон билээ. Чойгийн хувьд Пакийн хүсэлтээр урлаг спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоёр санг байгуулж, Ерөнхийлөгчийн бодлого зохицуулалтыг хариуцсан Ерөнхий нарийн бичгийн дарга асан Ан Чон-Бумын хамт олон томоохон корпорациудаас нийтдээ 65 сая ам.долларын хөрөнгийг хандив нэрийдлээр сандаа төвлөрүүлсэн гэх хэрэгт буруутгаж буй бол Ан Чон-Бумыг Ерөнхийлөгч Пак Гын Хегийн заавраар төрийн албаны нууцын зэрэглэлд багтах 47 баримт бичгийг Чойд дамжуулж, төрийн албаны нууцыг задруулсан гэх үндэслэлээр буруутгажээ. Мөн яллах дүгнэлтэд дурьдагдсанаар Пак өнгөрсөн жилийн долдугаар сард хэд хэдэн компаниудын удирдлагуудтай ээлж дараалан ганцаарчилсан уулзалт хийж, “Соёл, спортын үйл ажиллагаа явуулах сан байгуулахад хамтарч ажиллахыг” уриалж байжээ. Үүнээс прокурорынхон

Пак Ерөнхийлөгчийг Чойгийн хамтрагч гэж дүгнэсэн юм. Гэвч Ерөнхийлөгч өөрөө үгүйсгэсэн удаатай. Тэгвэл өчигдөр болсон анхны шүүх хурлын үеэр Чой прокуроруудын тулгасан ялыг үгүйсгэж, Пак уг хэрэгт оролцоогүй гэдгийг онцолсон байх юм.

Тодруулбал, Чойн өмгөөлөгч прокуроруудын яллах дүгнэлтэд тулгасан үндэслэлийг “бүгдийг нь хүлээн зөвшөөрөх боломжгүй” гэжээ. Түүнчлэн, Пак Гын Хе, Ерөнхийлөгчийн бодлого зохицуулалтыг хариуцсан Ерөнхий нарийн бичгийн дарга асан Ан Чон-Бумын аль алинтай нь хамтарсан зүйл байхгүй гэдгийг онцолжээ. Харин сандаа компаниудаас санхүүжилт авсан тухайд түүний өмгөөлөгч “Ердөө Ерөнхийлөгчийн үгийг л байгууллагуудад дамжуулсан төдий” гэж хариулжээ. Нөгөөтэйгүүр, Ерөнхийлөгчийн бодлого зохицуулалтыг хариуцсан Ерөнхий нарийн бичгийн дарга асан Ан Чон-Бумын өмгөөлөгч түүний үйлчлүүлэгчид тулгаж буй төрийн албаны нууц мэдээллийг задруулсан гэх хэргээ хүлээж байгаагаа мэдэгдсэн байх юм. Мөн Ерөнхийлөгчийн заавраар материалыг Чой Сун Шилд дамжуулсан гэх үндэслэлийг ч гэсэн хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлжээ. Ямартай ч, хэрэг хэрхэн эцэслэн шийдвэрлэгдэх нь олон улсын анхаарлын төвд байна. Гэхдээ эх сурвалжуудын зүгээс хэрэг шийдвэрлэгдэх хүртэл нэлээд хугацаа зарцуулахыг онцоллоо.

100 МОНГОЛ ШУУДАН

ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛЫН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙ ШИНЭ МАРКИЙН НЭЭЛТ

2016 оны 12-р сарын 21-ний өдөр 11:00 цагт **“ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛЫН МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙ”** сэдэвт шуудангийн маркийн Анхны өдрийн нээлт Их зээн Чингис хааны хөшөө, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолбор, **“МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ”**-д болох тул марк сонирхогч Та бүхнийг өргөнөөр оролцохыг урья.

“МОНГОЛ ШУУДАН” ХК
Утас: 70078990, 99769956

МОНГОЛ ШУУДАН
“МОНГОЛ ШУУДАН” ХК

ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙ НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу “Монгол шуудан” хувьцаат компанийн 2016 оны санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд аудит хийх гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулна. Сонирхсон байгууллага, аж ахуйн нэгжүүд дараах материалуудыг бүрдүүлж, 2016 оны 12-р сарын 26-ний өдрийн 17:00 цагаас өмнө “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд бичүүмжлэн ирүүлнэ үү.

Үүнд:

1. Байгууллагын танилцуулга /Томоохон аж ахуйн нэгжүүдэд аудит хийж байсан ажлын туршлагыг заавал оруулсан байна./
2. Аудитын хөтөлбөр /Хэдэн хүний
- бүрэлдэхүүнтэйгээр ямар ажлуудыг хийж гүйцэтгэх талаарх ерөнхий төлөвлөгөө/
3. Ажилчдын анкет болон НДЦ-ийн хуулбар
4. Үнийн санал

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 2-оос доошгүй Хувьцаат компанид аудит хийж байсан туршлагатай, ажил хэрэгч, мэргэжлийн, харилцагатай ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулалтад урьж байна.

Холбогдох мэдээллийг “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын 7007-8910 утсаар лавлана уу.

Хаяг: ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ “МОНГОЛ ШУУДАН” ХК Сүхбаатарын талбай-1, Чингэлтэй 1-р хороо, УЛИАНБААТАР 15160



АМЖИЛТЫН ЭЗЭН

Мисс А.Баярцэцэг “ДЭЛХИЙН МИСС”-ийн ШИЛДЭГ 11-Т БАГТЛАА

Дэлхийн гоо сайхны олимп гэгддэг “Дэлхийн мисс-2016” наадам АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд дэлхийн 120 гаруй орны гоо бүсгүй авьяас, чадвар, ур ухаанаа сорин өрсөлдсөнөөс эх орноо төлөөлөн оролцсон мисс А.Баярцэцэг гуравхан сая хүн амтай Азийн цэрэжинд орших Монгол Улсын түүхэнд байгаагүй амжилт гаргаж, шилдэг 11-т багтаж чадлаа. Харин 66 дахь удаагаа зохион байгуулагдсан “Дэлхийн мисс”-ийн титмийг Пуэрто Рико улсын мисс Стефани Дел Валле хүртжээ.

Тэрбээр Дэлхийн миссийн титмийг эх орондоо авчирсан хоёр дахь гоо бүсгүй болсон нь энэ юм. 66 дахь удаагийн “Дэлхийн мисс” Стефани Дел Валле 19 настай бөгөөд 1996 оны арванхоёрдугаар сарын 30-нд төржээ. Нью-Йорк хотын “Расс” их сургуульд харилцааны чиглэлээр суралцдаг тэрбээр испани, англи,

франц хэлээр чөлөөтэй ярьдаг байна. Дэлхийн миссийн тэмцээнд оролцохоосоо өмнө Пуэрто Рикогийн загвар зохион бүтээгч Карлос Албертогийн загварын шоунд оролцжээ. Стефанигийн хувьд шүүгчдийн саналыг хамгийн их авсан нь титмийн эзэн болоход нөлөөлсөн гэж үзэж байна. Харин нэгдүгээр байрт Доминикан улсын мисс шалгарсан бол хоёрдугаар байрт Зорилго бүхий гоо бүсгүй шалгаруулалтын ялагч Индонезийн мисс шалгарсан бол Монголын мисс “Олон



нийтийн

санал асуулга буюу масс хандалт”-аар тэргүүлж 120 гаруй орны миссээс 11-д шалгарч үлдсэн юм. Мөн “Авьяаслаг мисс”-ээр тодорч, элэг нэгт монголчуудаа баярлууллаа.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -15
Шөнө -22

Нөгөөдөр
Өдөр -16
Шөнө -23

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААН ХУЛГАНА ӨДӨР

Наран ургах шингэх: 08.38-17.01
Үс засуулбал: Идээ ундаа элбэг олдono



Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг туу нолоотэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр идээ, хувцас хунар олох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хоронго цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэх, харвал давах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал айлшиг болох, зүүн чих жингэнээвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал атгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэлцэл болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

Одгийн ЦАТ

Хейди Клат: Би загвараас үйдаж гадагхгүй

Орчуулсан Б.ДАВАА

Та 20 жил дотуур хувцасны загвар өмссөн. Харин эцэст нь зөвхөн Хайди Кламынх гэсэн загварыг олж чадсан уу?

Германд болсон загварын тэмцээнд түрүүлснийхээ дараа би загвар зохион бүтээгч болох хүслээ орхисон. Хэзээ ч дахиж энэ талаар бодож байсангүй. Харин загварын ертөнцөд олон жил ажиллаж, олон хүнтэй танилцсны дараа хүн бүр л ямар даашиг, гутал, женс, өмсвөл хамгийн гоё харагдах вэ, ямар даруулга зүүвэл тохиромжтой вэ гэдгийг мэдэхийг хүсдэг болсон. Тэгэхээр миний загварын мэдрэмж төрөлхийнх байх.

Хейди Клат Свим усны хувцасны коллекцийнхаа талаар яриач?

Усны хувцас, дотуур хувцас хэлбэрийн хувьд хоорондоо төстэй. Харин миний коллещид бага зэрэг сонгодог хэв маягийг оруулж өгсөн. Нэг үгээр хэлбэл, зөвхөн нөхөртөө харуулахын тулд эсвэл өөртөө зориулж л энэ хувцсыг өмсөхөд тохиромжтой. Миний хувьд классик загвартай учраас биед тааламжтайн дээр өнгө, материал, хэв маяг, хийц нь тун гайхалтай болж чадсан гэж боддог.

Таны хувьд хөхний даруулга зүүх тийм ч дуртай биш байх аа?

Би бага байхын л эцэг эхийнхээ хамт далайн эрэг дээр нүцгэн гүйж байдаг охин байж билээ. Одоо ч даруулга зүүх дургүй. Нүцгэн байхад ямар ч асуудал гардаггүй. Би өөрөө чөлөөтэй байх дуртай хүн л дээ. Далайн эрэг рүү ч юм уу, ямар нэг алслагдсан газар руу явахдаа олон хүн байхгүй бол

Эдүгээ 40 гарсан ч, 20 гаруй насны залуухан бүсгүй лэт харагддаг Германы загвар зохион бүтээгч, жүжигчин, телевизийн продюсер Хайди Клатд загварын тайзнаа алхаж явсан үе бий. Тэрбээр дотуур хувцасны алдартай брэнд Викториа Секретийн сахиусан тэнгэрүүдийн бүрэлдэхүүнд багтсан анхны Герман бүсгүй болж, спортын сэтгүүлийн нүүрийг чилж явсан удаатай. Харин 2008 оноос загварын тайзнаасаа бууж, бизнест хүч үзэх болсон юм. Тэгвэл энэ удаагийн “Оддын цаг” буландаа Хайди Клатын нэгэн сэтгүүлд өгсөн ярилцлагыг орчуулан хүргэж байна.

доруулгагүй явах дуртай.

Хайр дурлалын асуудал тань бүгдэд ил, сексийн талаар ч ер нь та яагаад ийм нээлттэй байдаг юм бэ?

Би далайн эрэг дээр олон хүний өмнө тэр бүр найз залуугаа үнсэж, тэврээд байдаггүй. Завинд суух, эсвэл хаа нэг тийшээ очиж, нуугдсаныхаа дараа л ийм байдал гаргадаг. Хэн ч байхгүй газарт л хайрттайгаа догтоо харилцаа үүсгэдэг. Харамсалтай нь папараццид биднийг байнга дагадаг. Нисдэг тэргээр эсвэл завь, бутны ард нуугдаж, усанд шумбагчийн хувцастай хүртэл гарчирэхийгнъяана. Гэтэл, тэдний авсан зургаар гадаад ертөнц биднийг бүхий л хүмүүсийн өмнө далайн эрэг дээр аалгүйтдэг юм шиг хүлээн авдаг.

Найз залуугийн чинь тухай ярихдаа хэвлэлийнхэн өөрийг тань “Пума” гэдэг юм билээ. /Клат 43 настай бол түүний найз залуу Шнабель 30-тай/?

Энэ нэр насны зөрүүтэй огт хамааралгүй. Бид нэг нэгэндээ хайртай, цагийг хамтдаа хөгжилтэй өнгөрүүлдэг. Маш гайхалтай гүн гүнзгий харилцаатай. Хүмүүс бидний талаар юу гэх бол гэдэгт би огтхон ч санаа зовдоггүй. Гэртээ орж хаалгаа хаагаад л хамтдаа гайхалтай цагийг өнгөрүүлдэг. Тэр л хамгийн чухал.

Та дөрвөн хүүхэдтэй. Хамгийн том нь өсвөр насанд хүрчихлээ. Та ер нь бэлгийн харилцааны талаар ярьж байв уу?

Гэд хүүхэд хэвлийд хэрхэн бүрэлддэг талаар мэднэ. Би чимээгүйхэн чиглүүлэхийг л илүүд үздэг. Хүмүүс намайг ямар хүн бэ гэдгийг мэднэ дээ.

Таны хамгийн их хөрөнгө зарцуулдаг зүйл тань урлаг. Харин Вито Шнабель урлагийн ертөнцөд танигдсан нэгэн. Та хоёр ямар харилцаатай байдаг вэ?

Би урлаг, математикийн чиглэлээр их сургуульд мэргэжил эзэмшсэн. Тийм ч учраас зураг зурах их дуртай. Хэн нэгэнтэй хамт зурах бүр ч сайхан байдаг юм. Харин одоо бол Вито бүхий л шинэ содон зүйлсийн талаар надад заадаг гайхалтай багшийн үүргийг гүйцэтгэдэг. Их Сургуульд сурч байхдаа өөр өөр цаг үеийн дэлхийн суутнууд, Пикассогийн тухай судалдаг байлаа. Харин одоо орчин үеийн урлаг, соёлын тухай илүү их судалж байна.

“Project Runway”-ын зургадугаар хэсэг нь дуусаны дараа кабелийн телевизийн хамгийн өндөр рейтингтэй шоу болж чадсан байсан. Одоо 15 дахь хэсэг нь үргэлжилж байгаа байх аа?

Хүмүүс надад хэлдэг юм. “Ийм



олон жилийн дараа ч гэсэн үүнийгээ хийхийг хүслээ гэж үү”, “уйтгартай биш байна уу” гэж. Би загвараас үйдаж чадахгүй. Яагаад гэвэл загвар үргэлж өөрчлөгдөж, шинэчлэгдэж байдаг. Тэр бол бодит хүн, бодит түүх. Ийм байтал загвараас яаж уйдах билээ.

АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трампын эмэгтэйчүүдийг зүй бус үгээр гутаан доромжилж байсны нэг илрэл нь өнгөрсөн жил таныг “Хейди Клат аль хэдийнэ 10 настай байхаа больсон” гэж хэлсэн явдал байлаа. Та сонгуульд саналаа өгсөн үү. Бас нэр дэвшигчдийн хэлт мэтгэлцээнийг үзэв үү?

Мэдээж, үзсэн. Гэхдээ улс төрийн талаар ярих их хүндрэлтэй санагддаг. Учир нь би энэ талаар тийм ч сайн мэддэггүй биш. Би Трампын төлөө хэзээ ч саналаа өгөхгүй. Тэр намайг 10-тай биш гэж хэлсэн учраас л саналаа өгөөгүй гэж ойлговол өрөөсгөл. Зүгээр л бид үзэл бодол нийлэхгүй хүмүүс.

Эцэг эхээс чинь сургасан ямар захиасыг нь хүүхдүүддээ хэлдэг вэ?

Үргэлж өөрийнхөөрөө бай, хэн гэдгээ хэзээ ч маргаж болохгүй гэж захидаг.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Sarangereel Jantsan



Манай хүү дунд сургуулийн сурагч юм. Сая гурван канестраар усанд явж ирсэнийхээ дараа “гар сарвайгаад хүнд байна” гэлээ. Би ч тоосонгүй. “Нэг нэгээр нь явахгүй яасан юм” гэсэн чинь “Би та гуравт зарагдаж байгаад даралт харвачихсан гэж сонсогдох вий дээ” гэдэг юм даа. Намайг дуурайж, биднийгээ айлгадаг боллоо. Ха ха ха

ДУУЛГАХ СОНИН

Б.Мягмарсүрэн их урлагтаа эргэн ирлээ



Рок попын ертөнцөд Ану гэх нэрээрээ танигдсан СТА, дуучин Б.Мягмарсүрэнгийн “Үүр шөнийн одоос асуугаарай” хэмээх дууг мэдэхгүй хүн цөөн болов уу. Түүний энэ дуу нэг хэсэгтээ л хит болж, олон ч залуусыг уярааж явсан удаатай. Гэвч, түүний нөхөр, нэрт яруу найрагч З.Түмэнжаргал агсан таалал төгссөнөөс хойш дуучин Б.Мягмарсүрэн хөгшин Европын “хаан” Франц улсыг зорьж, үр хүүхдээ өсгөхийн зэрэгцээ Сорбоны их сургуульд урлагийн чиглэлээр багшилж эхэлсэн байдаг. Тэгвэл “Ану” эх орондоо, их урлагтаа эргэн ирж, “Үүр шөнийн эх одоос асуугаарай” гэх амьд тоглолтоо өчигдөр “UB jazz” клубт зохион байгууллаа. Дуучин бүсгүй “Сайхан чамдаа”, “Үүр шөнийн одоос асуугаарай”, “Цахилах гөрөөс”, “Тэнгисийн цагаан бороо”, “Дууны хорвоо” зэрэг монголчуудын зүрх сэтгэлд хэдийнэ хоногшсон уран бүтээлээ толилуулсан байна.

SODON cleaning service

БҮХ ТӨРЛИЙН ЦОГИ ЦЭВЭРЛЭГЭЭ

АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их иэвэрлэгээ
- Гэрээт иэвэрлэгээ
- Гадна срасадны иэвэрлэгээ
- Гадна талбайн иэвэрлэгээ
- Барилгын бөлөн засварын дараах иэвэрлэгээ
- Үдэвчлэг хүлээн авалтын дараах иэвэрлэгээ

АЙЛ ӨРХИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их иэвэрлэгээ
- Энгийн иэвэрлэгээ
- Хэсэгчилсэн иэвэрлэгээ
- Цонх тагтны иэвэрлэгээ
- Цонх тагтны засвар үйлчилгээ
- Хивс, хивсэнээр иэвэрлэгээ

УТАС: 95018180, 88120500, 99003618

FACEBOOK: SODON SERVICE